

2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БИЧМЭЛ ТАЙЛАН

2019 онд:

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

“ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ЖИЛ”

ЭМЯ:

“ИНЭЭМСЭГЛЭЛ- ЭЕРЭГ ХАНДЛАГА”-ЫН ЖИЛ

НИЙСЛЭЛ :

ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХӨГЖЛИЙН ЖИЛ

НЭМГ:

**ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ
ЖИЛ**

ДҮҮРЭГ:

**“ИРГЭДИЙН АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЖИЛ” –
“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ЭЭЛТЭЙ ДҮҮРЭГ”**

Тайлант хугацаанд Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв нь Нийслэл болон дүүргийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн амын эрүүл мэндтэй холбоотой асуудлыг Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоол, шийдвэр дүрэм журмын дагуу шийдвэрлэж ажиллаа.



АЛСЫН ХАРАА:

“Эелдэг харилцаа –Чанартай үйлчилгээ”



ЭРХЭМ ЗОРИЛГО:

“Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг нэмэгдүүлэн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар цогц үйлчилгээтэй манлайлагч эмнэлэг болно”

Тус Эрүүл мэндийн төв нь 1978 он буюу 40 жилийн өмнө Багануурын уурхайг түшиглэн Нүүрэнтэйн хөндийд гэр барьж анхныхаа галыг бадраан, 5 ортой, 3 орон тоотой их эмчийн салбар үүсэн байгуулагдаж байсан бол өдгөө Монгол улсын 2 дугаар шатлалын томоохон Эрүүл мэндийн төв болон хөгжиж 230 ортой, 17 тасаг нэгжтэй, 314 эмч, эмнэлгийн ажилтантайгаар дүүргийн 5 хорооны 29512 хүн ам, Төв, Хэнтий аймгийн хил залгаа сумдын 30000 орчим хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан, хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг Нэгдсэн эмнэлгийн бүтэц орон тооны стандартын дагуу үзүүлэн ажиллаж байна.



Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 03 дүгээр сарын 28-ны өдрийн “Дүрэм бүтэц батлах тухай” А/44 дугаар тушаалаар ЭМТ-ийн ерөнхий бүтэц, хэлтэс, алба, тасаг нэгжүүдийн зохион байгуулалтыг шинэчлэн ажиллаж байна.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

“Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”, МУ-ын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”, МУ-ын засгийн газрын (2016-2020) үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын (2016-2020) үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын (2016-2020) үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэл дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгүүлэх үндсэн чиглэлд тусгасны дагуу дараах ажлуудыг 2019 онд хийж гүйцэтгэсэн.

Нийслэлийн эдийн засаг, нийгэмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 3 заалт, 4 арга хэмжээ, дүүргийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан 4 заалт, 19 арга хэмжээний хэрэгжилтийг тус тус хангах чиглэлээр жилийн ажлаа төлөвлөн **2019 онд нийт 8 чиглэлийн хүрээнд 63 ажил, төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөний биелэлтийн хувь 92%** байна.

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв нь ЭМСайдын 2018 оны 04-р сарын 30-ны өдрийн А/166 тоот тушаалаар 2018 оны 3-р сарын 13-наас 2022 оны 3-р сарын 13 хүртэл 4 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэгдсэн. Магадлан итгэмжлэх комиссын зөвлөмжийн дагуу чанарын хөгжлийн хөтөлбөрийг 6 зорилтын хүрээнд 22 чиглэлээр боловсруулан ЭМЯ –ны Эмнэлгийн тусламжийн газрын даргаар батлуулан чанар сайжруулах жилийн төлөвлөгөөг 4 бүлэг 28 заалттай гарган байгууллагын даргаар батлуулж, мөрдөн ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөний биелэлт 98,2% байна.

Засгийн газрын тогтоолоор батлагдсан 10 үндэсний хөтөлбөр 3 стратегийн хэрэгжилтийг орон нутгийн түвшинд хангаж ажиллаж байна. Тайлант хугацааны хэрэгжилтийн хувь 91,3% байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: “ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

Бүтэц үйл ажиллагааны хэрэгжилт:

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв нь 230 ортой /өдрийн 16 ор/, 17 тасаг, нэгжтэйгээр дүүргийн болон Төв, Хэнтий аймгийн ойролцоох сумдын хүн амд нэгдсэн эмнэлгийн бүтэц, орон тооны стандарт MNS 5095:2017-ын дагуу тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Эмчилгээ, оношлогооны стандартын хэрэгжилт: Өвчний түүх бичилт, анхан шатны маягт хөтлөлт, эмчилгээ, оношлогооны стандартад тогтмол хяналт тавин ажиллаж байна. Түгээмэл үйлдлийн стандартын хэрэгжилт:

2018 онд 86,1%

2019 онд 87,6%

Цэвэрлэгээ, үйлчилгээний стандартын хэрэгжилт:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тав тухтай орчинд үзүүлэх нөхцөл боломжийг хангах, цэвэрлэгээний чанарыг стандартын түвшинд байлгаж дотоод халдвар гаргахгүй ажилласан. Цэвэрлэгээний чанар өмнөх онтой харьцуулахад 8% хувиар өсөж, 96% -д хүрсэн. MNS5095:2017 стандарт, ЭМС-ын 169,187, 505

тоот тушаалын дагуу давхардсан тоогоор 185 ажилтанд 794 удаа хяналт тавин цэвэрлэгээ үйлчилгээ, халдвар хамгаалал, ёс зүйн санал гомдол гаргалгүй ажилласан.

Тогтоолуудын хэрэгжилтийн байдал:

- Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг хангах чангатгах тухай албан даалгаврын хэрэгжилт 98%
- 2018.08.22-ны 2018/258 тоот тогтоолын чиг үүргийн дагуу хамаарах зүйл заалтын хэрэгжилтийн дундаж хувь 94%
- Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил болгох тухай 2019.01.16-ны өдрийн 2019/23 тоот тогтоолын хэрэгжилтийн хувь 97%
- Дүрэм батлах тухай 2019 оны 33 дугаар тогтоолын хэрэгжилт 96%
- Монгол Улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил” -ийн хүрээнд зохион байгуулах ажлын тухай 2019.01.16-ны өдрийн 03 тоот тогтоолын хэрэгжилт 91%
- Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2018.07.09-ны өдрийн 119 тоот тогтоолын хэрэгжилтийн хувь 97%

Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх ЭМС-ын 186,187 тоот тушаалыг хэрэгжүүлэхээр:

- “Эмнэлгийн тусламж үйлчилгээний халдвараас сэргийлэх нь”сэдэвт сургалтанд 36 үйлчлэгч хамрагдсан.
- Цэвэрлэгээний стандарт хэрэгжилтэнд ЭМС-ын 187 тоот тушаалын дагуу нэмэлт үзүүлэлт гаргаж хяналтын карт, чек листээр 34 үйлчлэгчийг давхардсан тоогоор 426 удаа хяналт үнэлгээг хийхэд үр дүн 88%-96% болж өссөн.
- ЭМС-ын 169 тоот тушаалын тасаг нэгжийн цэвэрлэгээ үйлчилгээг үнэлэх хуудсаар 17 тасаг нэгжийг 368 удаа үнэлэхэд дундаж үнэлгээ 88,2%-94,4% болж ахисан
- ЭМС-ын 187 тоот тушаалын 5-р хавсралт “**Асгарсан цацагдсан цус хүний биологийн шингэн цэвэрлэх**” дарааллаар чек лист боловсруулан үнэлгээний хуудсаар давхардсан тоогоор 34 үйлчлэгчийг 4 удаа үнэлэхэд 89%-96,8%-тай үнэлэгдсэн.
- ЭМС-ын 187 тоот тушаалын 2-р хавсралт ЭМА-ны гарын эрүүл ахуйн үнэлгээний хуудсаар 35 үйлчлэгчийг тус тус 3 удаа үнэлэхэд 89,2%-96,8% болж ахисан.
- ЭМС-ын 187 тоот тушаалын 5-р хавсралт “**Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх заавар**” –аар 38 үйлчлэгчид сургалт хийж, асгарсан, цацагдсан цус, биологийн шингэнийг халдваргүйжүүлэн цэвэрлэх цомог, иж бүрдлийг цэвэрлэгээний нэгж талбай бүрд бэлтгэн хэрэглэж хэвшсэн
- Эмнэлгийн бүх талбайг 3 бүсээр ангилан ялгаж нэгдсэн нэг загварын таних тэмдэгээр өрөө талбай бүрийг хаягжуулсан.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээг цэвэр аюулгүй орчинд үзүүлж, үйлчлүүлэгчдийн тав тухыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлэх үүднээс дотор 13,3 мянган мкв талбай, гадна 7650 мкв талбайн цэвэрлэгээг ЭМС-ын 187 тоот тушаалын 5-р хавсралтыг үндэслэн өдөр тутам болон сар бүр их цэвэрлэгээний журам, хуваарь гарган батлуулан түүний дагуу хяналтыг 568

удааа хийж, халдвар хамгааллын зөрчил гаргалгүй үйлчлүүлэгчдийн тав тух, 96%-ийн сэтгэл ханамжинд нийцүүлэн зохион байгуулалтыг хийн үйлчлүүлэгчдээс санал гомдол гаргуулалгүй ажилласан.

“Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент”, ЭМС-ын 505 тоот тушаалаар:

- ЭМС-ын 505 тоот тушаалыг хэрэгжүүлэхээр эмнэлгийн тусгай хог хаягдлыг түр хадгалах өрөө, эхсийн нүхийг шинээр байгуулж, үйл ажиллагааг стандартын дагуу хэвийн явуулж эхэллээ.



ЭМС-ын 505 тоот тушаалын заавраар шинэчлэн гаргаж, түүний дагуу бүртгэн мэдээ тайланг сар бүр ХӨСҮТ-д мэдээллэн ажиллаж байна. Үүнд:

- ❖ Халдвартай хог хаягдал – 11225,5 кг
- ❖ Хурц үзүүртэй иртэй хог хаягдал- 2862,5 кг
- ❖ Эмгэг хог хаягдал- 778,3 кг
- ❖ Эмийн болон эсэд хортой хог хаягдал- 50,6 кг
- ❖ Эмийн болон химийн бодисийн хог хаягдал 62 кг-ийг цуглуулж “Элемент” ХХК-тай гэрээ хийж, гэрээний дагуу зөөвөрлөн устгасан.

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн сувилгааны алба нь удирдах дээд байгууллага, мэргэжлийн нийгэмлэгүүдээс сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр 9 тушаал шийдвэр, албан тоот, хүлээн авч 41 сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдан гүйцэтгэл 100% байна. Үүнд:

- НЭМГ-ын 2019-01-22 өдрийн 2/43 тоот “Гэмтэл согогийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах нь” 1 багц цагийн сургалт
- ЭМХТ-ийн даргын 2019-02-12 160 тоот Жайка олон улсын байгууллага ЭМЯ-ны ёс зүйн хяналтын хороотой хамтран зохион байгуулах “Ёс зүй” сэдэвт сургалт
- ЭМХТ-өөс 2019-02-26 ЭМЯ-аас дэвшүүлсэн “1:2” зорилтын хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөц, ёувилахуйн албаны дарга нартай хийх уулалт
- НЭМГ-ын даргын 2019-04-04 өдрийн 2/272 тоот, УГТЭ-ийн 201-04-01 271 тоот “Дотрын өвчний үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний цогц шийдэл” улсын хэмжээний сургалт
- НЭМГ-ын даргын 2019-04-22 2/334 тоот ОУСӨ угтан Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулах 2-р шатны эрдэм шинжилгээний хуралд оролцох
- НЭМГ-ын даргын 2019-05-07 2/377 тоот УХТЭ-ээс ОУСӨ –ийг улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх нэгдсэн арга хэмжээнд оролцох тухай

- МСН-ийн тэргүүний 2019-05-28 10 тоот ЭМЯ хамтран зохион байгуулж буй “Сувилагчийн тангараг өргөх ёслол”-ын үйл ажиллагаанд сувилагч нарыг оролцуулах тухай
- САТ-өөс 2019-05-07 зохион байгуулсан “Алтан дэнлүү-2019” ёслолын үйл ажилагаанд оролцох
- МСН-ээс 2019-05-08 нд жил бүр зохион байгуулдаг Хандивын тоглолтын үйл ажиллагаанд оролцох

ГУРАВДУГААР БҮЛЭГ:
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1 НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ:

А. Нийгмийн эрүүл мэндийн салбар хоорондын хамтын ажиллагаа

Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”, НЭМГ, ЭМЯ “Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах” жил болгон зарласантай холбогдуулан гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр төлөвлөсөн зорилтуудыг хэрэгжүүлэх, Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, сурах, хөдөлмөрлөхөд таатай орчин нөхцөлөөр хангах, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хөгжлийн үйлчилгээг гэр бүлд хүргэх ажлыг эрчимжүүлээд байна.

Багануур дүүргийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн зөвлөл нь 2019 онд “гэр бүл, эх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хамт олон, олон нийтийг” гол чиглэлээ болгон ажиллахаар төлөвлөн дүүргийн “НЭМСЗ-ийн зөвлөлдөх уулзалт”-ыг 2019.05.07-ны өдөр зохион байгуулж дүүргийн НЭМСЗөвлөлүүдийн сайн туршлага, цаашид хийх ажлын чиглэлээ тодорхойлсон. Тус зөвлөлдөх уулзалтанд 52 ААН, байгууллагуудын 89 НЭМСЗ-ийн дарга, гишүүд оролцсон.

Дүүргийн НЭМСЗ-ийн 2 дах удаагийн уулзалтыг 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлье”, “Тэмбүүг устгая”, “БЗДХ-аас сэргийлье” зэрэг сэдвүүдээр мэдээлэл, сургалт зохион байгуулж, дүүргийн НЭМСЗ-ийн 2019 оны төлөвлөгөөний биелэлт, явцыг ярилцаж, ажлын чиглэл өгсөн. Уулзалтанд 24 байгууллагын 37 гишүүд оролцож, санал солилцон, цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцлаа.

Б. Зохион байгуулсан өдөрлөг, аян, хөдөлгөөн

“Өглөөний Багануурчууд” хөдөлгөөн: Дүүргийн Засаг даргын 2018 оны 03 сарын 01-ний өдрийн А/56 тоот захирамжаар 2019.05.01-2019.10.01-ны өдрийг хүртэл хугацаанд **“ӨГЛӨӨНИЙ БАГАНУУРЧУУД”** уриан дор дасгал хөдөлгөөнийг өглөө бүр 06:00-07:00 цагийн хугацаанд хийж хэвшүүлэх ажлыг зохион байгуулан өглөө бүр 20-45 хүн тогтмол хамрагдаж байна. Мөн 987 гишүүнтэй “Өглөөний Багануурчууд” FACEBOOK group ажиллуулж, зураг, зар, мэдээ, мэдээллийг өдөр тутам байршуулан ажиллаж байна.



“Өдөр бүр дасгал, хөдөлгөөн хийцгээ” уриан дор бүх нийтийн FLASH MOB: Дүүргийн Биеийн тамир спорт хороо, Усан спорт боулингийн төвтэй хамтран дүүргийн хүн амын дунд халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, дасгал хөдөлгөөн, нийтийн биеийн тамираар хичээллэхийн ач холбогдлыг сурталчлах зорилгоор бүх нийтийн FLASH MOB-г дүүргийн төв Нацагдоржийн талбайд зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд дүүргийн иргэд, БААН-дийн ажилтан албан хаагчид, ахмадууд, ЕБС, МСҮТ-ийн сурагчид нийт 200 гаруй хүн оролцсон.

Энэ үеэр Залуучуудын “FLASH MOB”, Ахмадын “FLASH MOB”, Сурагчдын “FLASH MOB”-г бүх нийтээрээ хийж, Оюуны эрин цогцолбор сургуулийн сурагчид Японы “РАЙДО ТАЙСО” дасгалыг хийсэн.



“Үүргэвчтэй дугуйн аялал”: Багануур дүүргийн Засаг даргын 2018 оны 03 сарын 01-ний өдрийн А/56 тоот захирамжийн дагуу 2019 оны 06-р сарын 21-ний өдөр Багануур ХК, Багануур Сувилал ХХК, Багануурын Дулааны станц ТӨҮГ хамтран “Үүргэвчтэй дугуйн аялал” зохион байгуулж, Багануур дүүргийн НЭМТ, Биеийн тамир спорт хороо дэмжлэг үзүүлэн оролцлоо. Дүүргийн аж ахуйн нэгж, албан байгууллагын 13 баг, зохион байгуулагч 70 гаруй хүнийг хамарсан арга хэмжээ болж өндөрлөлөө.



“Хамтдаа иога хийцгээ” өдөрлөг: Дүүргийн засаг даргын 2018 оны 03 сарын 01 өдөр А/56 захирамжийн хүрээнд нийгмийн эрүүл мэндийн өдрийг сар бүр албан байгууллага, иргэдий оролцоотой зохион байгуулж байгаа бөгөөд 06-р сарын 28-ний өдөр “Нийгмийн эрүүл мэндийн төв, ЗДТГ, ИТХ ажлын алба, ХХҮХ, УИБХ, зэрэг байгууллагууд хамтран “ХАМТДАА ИОГА ХИЙЦГЭЭ” үйл ажиллагааг зохион байгуулсан. Арга хэмжээнд нийт 12 байгууллагын 119 иргэд, ажилтан, албан хаагчид оролцож, оролцогчидод зарим эрүүл мэндийн тусламжийг өрхийн эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүд үзүүллээ.



“Аэробек”-ийн өдөрлөг: 2019 он 07-р сарын 26-ны өдөр Усан спорт, боулингийн төвтэй хамтран "Аэробек өдөрлөг" -ийг амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгт нийт 16 байгууллагын 52 ажилтан, алба хаагчид оролцсон бөгөөд энэ үеэр 30 минутын “Хөгжимт аэробек” –ийн дасгалыг хийж, Усан спорт, боулингийн төвтэй танилцан, оролцогчдыг багт хуваан боулинг тоглуулж, дасгал хөдөлгөөний ач холбогдлыг сурталчиллаа.



“Зүрхний дутагдлын талаарх иргэдэд зориулсан өдөрлөг”: 2019 оны 5 сарын 7, 9, 10-ны өдрүүдэд иргэдэд болон “Багануур Дулааны Станц” ТӨХК-ийн ажилчдад “Зүрхний дутагдлын талаарх иргэдэд зориулсан өдөрлөг” –ийг зохион байгуулж сургалтанд хамрагдагсдын даралт, жин, өндрийг хэмжиж, зүрх судасны эрсдлийг тооцон зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулсан. Нийт 124 иргэд хамрагдаж сургалтанд оролцсон.



“Даралт хэмжилтийг дадал болгоё” аян: Артерийн гипертензийн эрт илрүүлэг, Эрүүл зүрх, ХБӨ-ий эрт илрүүлэг зэрэг хөтөлбөрийн хүрээнд тасралтгүй зохион байгуулж ажиллаж байна. Аяны хүрээнд дүүргийн бүх хороодод болон НЭМТ, ЭМТ-ийн амбулаторийн тасаг, 103, хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг нэгжүүдэд болон Монос эмийн сангийн салбаруудад даралт хэмжих цэгүүд ажиллаж байна. Цаашид дүүргийн хэмжээнд даралт хэмжих цэгүүдийг олноор бий болгох зорилгоор олон нийтийн газар, банкуудад даралт



хэмжих цэгүүдийг байршуулж, нэмэгдүүлэх ажлыг дүүргийн танилцуулахаар төлөвлөөд байна. Аяны хүрээнд нийт 1088 хүний артерийн даралтыг хэмжиж, зөвлөгөө өгснөөс даралт ихсэлт шинээр оношлогдсон 159 хүнийг хяналтанд авч, ажиллаж байна.

“Дэлхийн тамхигүй өдөр”-ийн хүрээнд зохион байгуулсан “Өдөр бүрийг тамхигүй өдөр болгоё” сэдэвт аян: Аяны хүрээнд дүүргийн хэмжээнд 1 уулзалт хэлэлцүүлэг, 1 өдөрлөг зохион байгуулан, ААНБ-дын ажилтан албан хаагчдад, тамхины хор уршгийг сурталчлах ажлыг эрчимжүүлэн ажилласан. Үүний хүрээнд 2019.03.25-ны өдөр дүүргийн ИТХ, ЭМТ, НЭМГ, СЭМҮТ, НЭМГ-ын харьяа Наркологийн эмнэлгийн дарга, удирдах ажилтан, мэргэжилтнүүд дүүргийн ААНБ,



ЕБС, ЗДТГ-ын нийт 80 орчин ажилтан, албан хаагчид оролцсон **“АРХИ, ТАМХИНЫ ХОР НӨЛӨӨНӨӨС СЭРГИЙЛЬЕ”** сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

“Өдөр бүрийг тамхигүй өдөр болгоцгоё” уриан дор **27 удаагийн сургалтанд нийт 1117** иргэдийг хамруулж, сургалтын үр дүнд нийт **24** хүн тамхинаас гаргах шийдвэр гаргасан ба үйл ажиллагааны хүрээнд нийт **1350** ш гарын авлага тараагдсан байна. Мөн орон нутгийн **“Сүлжээ-3”** телевизээр уулзалт хэлэлцүүлэг, өдөрлөгийн 3 уда арга хэмжээг сурталчилсан.



“Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” өдөрлөг: Багануур дүүрэгт зам тээврийн шалтгаант осол, гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулах, иргэд, олон нийтийн оролцоог хангах, аюулгүй орчин нөхцөл бүрдүүлэх зорилгоор тус 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 11 цагт дүүргийн Нацагдоржийн талбайд зохион байгууллаа.

Өдөрлөгийг дүүргийн ИТХ, ЭМТ, Гэр Бүл, Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Төв, Цагдаагийн хэлтэс, дүүргийн Замын цагдаагийн тасаг, Өргөө соёлын төв, Биеийн тамир спорт хороо хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээг Багануур дүүргийн ИТХ-ын С. Даваасүрэн нээж, Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч О.Чулуунбаатар, Засаг даргын гэр бүл, хүүхэд, жендэрийн асуудлын орон тооны бус зөвлөх Ц. Цогзолмаа, Тээвэр зохицуулалтын алба, сурагчдын төлөөлөл олон нийтэд чиглэсэн уриалга, сэрэмжлүүлэг хүргэж, плаш моби бүжгийг хамтдаа бүжиглэлээ. Үйл ажиллагаанд нийт 35 аж ахуйн нэгж, байгууллага хороод, ӨЭМТ-үүд хамтран оролцсон бөгөөд нийт 250 орчим ажилтан, албан хаагчид, иргэдийг хамрууллаа.

Спорт явган алхалтыг “ГҮЙЕ ТҮҮЕ” сэдвийн дор зохион байгууллаа: Дүүргийн хэмжээнд уламжлалт явган аялалыг 2019 оны 09-р сарын 14-д “ГҮЙЕ ТҮҮЕ” нэрийн дор зохион байгуулж нийт 13 байгууллагын 105 ажилтан албан хаагч иргэд оролцлоо.



“Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын төлөө дуу хоолойгоо нэгтгэцгээе” өдөрлөг: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал нь дэлхийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэл хэмээн хүлээн зөвшөөрч Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 72-р чуулганаар жил бүрийн 9 сарын 17-ны өдрийг Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр болгон тэмдэглэхээр шийдвэрлэсний дагуу ЭМЯ болон НЭМГ-ын гаргасан удирдамжийн дагуу БНЭМТөв нь “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын төлөө дуу хоолойгоо нэгтгэцгээе” уриан доор нээлттэй өдөрлөгийг 2019.09.19-ний өдөр эмнэлгийн гадна талбайд зохион байгууллаа. Өдөрлөгт хүрэлцэн ирсэн иргэдээ хүчилтөрөгчийн коктейлоор дайлж, цусны даралт хэмжих, цусны сахар тодорхойлох зэрэг хэрэгцээнд тулгуурсан анхан шатны үйлчилгээг 250 орчим иргэдэд үзүүлснээс 60 орчим ахмад настанг эхо, зүрхний бичлэг, даралт үзэх арга хэмжээнд хамруулан, эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн байна.



“Ахмад настан-Хэрэглэгч” сэдэвт өдөрлөг: Багануур дүүргийн ЭМТ-ийн НЭМТ, Амбулаторын ахмадын кабинет, ӨЭМТ-үүд хамтран “Ахмад настан-Хэрэглэгч” сэдэвт өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт оролцсон 85 өндөр настны 60 хүний сахар тодорхойлон, элэгний вирусын шинжилгээ, эрүүл мэндийн багцын үзлэгт хамруулан, эрүүл мэндийн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулан, 150 ширхэг гарын авлага тараалаа.



“Хүүхдийг эхийн сүүгээр хооллох бодлогыг дэмжих Дэлхийн долоо хоногийг тэмдэглэн өнгөрүүлэх” Дэлхийд жил бүрийн наймдугаар сарын 1-7-ны өдрийг “Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих өдөр” болгон уламжлал болгон тэмдэглэдэг бөгөөд энэ жил “Эхэд ээлтэй ажлын байрыг дэмжицгээе” уриан дор тэмдэглэлээ.

Багануур дүүргийн ЭМТ-ийн НЭМТ, нярайн тасаг, жирэмсний зөвлөгөө өгөх кабинет хамтран 2 удаагийн сургалт хийн, жирэмсэн болон тасгаар үйлчлүүлж буй 36, 4 ӨЭМТ-үүд 78, нийт 114 иргэд “Хүүхдийг хөхөөр хооллохын ач тус”-ыг сурталчлан, 320 ш гарын авлагыг иргэдэд тарааж, 20 жирэмсэн эмэгтэйд хүчилтөрөгчийн коктейлээр үйлчилсэн байна.



В. Эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ

Нийслэлийн Засаг даргын А/320 тоот захирамжаар батлагдсан “Эрүүл иргэн” аяны хүрээнд:

- Хороодын зорилтот бүлгийн иргэд-135
- Сүрьеэ илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт-2290
- Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг-1954 иргэд тус бүр үзлэг шинжилгээнд хамрагдлаа. Мөн сургалт сурталчилгааг үзлэгт ирсэн иргэдийн дунд зохион байгуулж нийт 1890 хүн хамрууллаа.

Хороодын зорилтот бүлгийн иргэдэд нарийн мэргэжлийн үзлэг оношилгоо, шинжилгээг хагас жил тутамд нийтдээ 2 удаа зохион байгууллаа.

1-дэх удаа нь: 2019 оны 05 сарны 24, 29-нд 4,5-р хороо, 06-р сарын 14-нд 1-р хороо иргэдэд үзлэг хийж нийт 65 зорилтот бүлгийн иргэд хамрагдсан
2 дахь удаа нь 2019 оны 10 сарны 16,25-д 5,4-р хороо, 11-р сарын 1,8-нд 3, 1-р хороо иргэдэд үзлэг хийж нийт 70 зорилтот бүлгийн иргэд хамрагдсан.

ХБӨ-ний эрт илрүүлгийн үзлэг: Жил бүр ӨЭМТ-үүд дээр Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт шаардагдах хөрөнгийн зардлын судалгааг гаргуулан Засаг даргын нөөцөөс санхүүжүүлдэг. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг 2019 оны 10-р сарын байдлаар:

- Хөхний өмөн өвчний эрт илрүүлэг -7833 хамрагдахаас 3380 буюу 43,2%,
- умайн хүзүүний өмөн өвчний эрт илрүүлэг -1792 хамрагдахаас 894 буюу 49.9 %
- Артерийн даралт ихсэх, өвчний эрт илрүүлэг -7920 хамрагдахаас 4614 буюу 58.3%,
- чихрийн шижин өвчний эрт илрүүлэг -7920 хамрагдахаас 4674 буюу 59%, тус тус хамрагдсан байна.

“Элэг бүтэн үндэсний хөтөлбөр”: Хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийнхэнд вирус илрүүлэх шинжилгээг ӨЭМТ-үүд дээр зохион байгуулж 2019 оны эхний 10 сарын байдлаар нийт 1695 хүн хамрагдсан бөгөөд В вирус - 163 хүнд, С вирус - 173 хүнд илэрсэн байна. ЭМТ-ийн молекул-биологийн лабораторит С вирусын ачаалал тодорхойлох шинжилгээг 2019 оны 06 сарын 01-н хүртэл нийт

87 хүнд хийсэн байна. ЭМТ-ийн дотор, халдвартын кабинетын эмчийн хяналтанд 2019 онд В-вирус 56, С-вирус -97 хүн эмчлэгдэж С-вирусын эмчилгээ бүрэн дууссан -47 хүн байна. НЭМ-ийн өдөрлөгүүдийг сар бүр тодорхой сэдвийн дор зохион байгуулж нийт 13 өдөрлөгийг дүүргийн албан байгууллага, иргэдийг хамруулан зохион байгуулж өдөрлөгт оролцсон 800 гаруй иргэдэд Элэг бүтэн Монгол хөтөлбөрийг танилцуулан хамрагдаагүй иргэдийг өдөрлөгийн үеэр хамруулан ажиллаа.

Молекул биологийн лабораторийн үйл ажиллагаа: Уг лаборатори нь ЭМЯ-аас зохион байгуулсан Элэгний С вирусын ачаалал тодорхойлох шинжилгээ хийх эрх бүхий 22 лабораторийн дунд ONE WORLD ACCURACY олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан гадаад хяналт, үнэлгээ, шинжилгээнд амжилттай хамрагдсан. 2019 оны 3 сард “Австралийн ONE WORLD ACCURACY”-ийн НЛА-аас явуулдаг гадаад хяналтанд хамрагдаж гэрчилгээгээ авсан чанарын гадаад хяналтанд 2 удаа хамрагдсан. С вирусын идэвхижил тоолох шинжилгээг 2019 оны 06 сар хүртэл хугацаанд нийт 87 хүнд гепатит С вирусын ачаалал тодорхойлох шинжилгээ хийсэн байна. 2019 онд нийт 5 аж ахуйн нэгж, албан байгууллагын 250 ажилчдад зохион байгуулсан. Хагас жилээс хойш молекул биологийн лабораторийн эмчгүй байгаатай холбоотойгоор вирусын ачаалал тодорхойлох шинжилгээ хийгээгүй байна.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх өртөөчилсөн үзлэг, оношлогоог зохион байгуулж байна. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх өртөөчилсөн үзлэгийг 2019 оны 10 сараас эхлэн зохион байгуулж дараах үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- Даатгуулагчийн багцийн үзлэг, шинжилгээ /биеийн бүрдмэл үзлэг, АД хэмжих, ЭХО, өөх тосны солилцооны шинжилгээ, Зүрхний цахилгаан бичлэг, умайн хүзүүний хавдрын эсийн шинжилгээ, Рентен оношлогоо, түрүү булчирхайн үзлэг/,
- Биеийн найрлага тодорхойлох /биеийн усны хэмжээ, өөхлөлтийн хэмжээ, биологийн нас, биеийн жингийн индекс, бодисын солилцооны эрчим/,
- Элэгний В,С вирус тодорхойлох,
- Захын судсанд сахар тодорхойлох зэрэг үзлэг, шинжилгээ хийгдэж,
- Халдварт болон халдварт бус өвчний эрсдлийн асуумж /сүрьеэ өвчний эрсдлийн асуумж, ходоодны хорт хавдрын эрсдлийн асуумж, чихрийн шижингийн эрсдлийн асуумж/ аван, эрсдлийг тодорхойлох ажлууд хийгдэж байна. Өртөөчилсөн үзлэгт 11 сарын байдлаар нийт 6 байгууллагын 127 иргэд, ажилтан, албан хаагчид хамрагдсан байна. Үүнд:
 - Төр захиргааны байгууллагын удирдлагууд
 - Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид
 - Нийгмийн даатгалын хэлтэс
 - Иргэдийн хурлын ажлын алба
 - 193-р цэцэрлэг
 - ГБХЗХХ

- Хороодын хөгжлийн бэрхшээлтэй иргэд



2019 оны эрүүл мэндийг дэмжигч байгууллага, эрүүл мэндээ дээдлэгч өрх, иргэн шалгарлаа: Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэл, зорилтын хүрээнд нийслэлд албан байгууллага, хамт олны дунд Эрүүл мэндийн сайдын 2009 оны 184 дүгээр тушаал, мөн өрх, иргэдийн дунд Нийслэлийн Засаг даргын 2003 оны 504 дүгээр захирамж, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2015 оны А/55 тушаалын болзолт журмын дагуу “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, “Эрүүл мэндээ дээдлэгч өрх, иргэн” шалгаруулах ажлыг 15 дахь жилдээ дүүрэг болон нийслэлд амжилттай зохион байгуулж, 2019 оны 10 сард дүүргийн хэмжээнд эрүүл мэндийг дэмжигч өрх, иргэн, байгууллагын шалгаруулалтыг хийж, шалгарсан 5 өрх, 5 иргэн, 2 байгууллагын материалыг НЭМГ-т хүргүүлсэн бөгөөд өөрийн байгууллагадаа эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэн, хамт олныхоо ажиллах, сурах орчныг сайжруулах талаар идэвхи зүтгэл, санаачилга гарган нийгэм, хамт олны төлөө ажиллаж, бусдад үлгэр дуурайлал үзүүлэн, архи, тамхигүй хамт олон болсон зэрэг 68 үзүүлэлтийг хангасан Багануур дүүргийн ШШГ- 0427 дугаар хаалттай хорих ангийг Нийслэлийн Эрүүл мэндийг дэмжигч байгууллагаар өргөмжилж, гэрчилгээ олголоо.

“Эрүүл мэндээ дээдлэгч өрх”-ийг 2 бүлэг 12 шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн бол, “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”-ийг болзол, журамд заасны дагуу эрүүл аж төрөх зан үйлийг амьдралдаа хэрэгжүүлж хэвшүүлсэн, эрүүл мэндийн мэдлэгээ бусадтай хуваалцдаг, энэ чиглэлээр нийгэм, хамт олонд дорвитой ажлуудыг санаачлан хэрэгжүүлсэн, аливаа хорт зуршлаас ангид байдаг, эрүүл хооллолт идэвхитэй хөдөлгөөнийг эрхэмлэдэг гэхчилэн 10 шалгуур үзүүлэлтээр дүгнэж, 5-р хорооны иргэн Л.Эрдэнэчулууны гэр бүл нийслэлийн “Эрүүл мэндээ дээдлэгч өрхөөр”, 1-р хорооны иргэн С.Эрдэнэбилэг, 3-р хорооны иргэн М.Мария нар нийслэлийн “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”-ээр тус тус шалгарлаа.





“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх өдөрлөг” зохион байгууллаа:

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/162 дугаар тушаалын дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжих сарын аян”-ыг Багануур дүүргийн хэмжээнд зохион байгуулж аяны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2019 оны 11-р сарын 15-ны өдөр дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх зорилго бүхий өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт нийт 58 хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдсан бөгөөд биеийн өөх тосны солилцооны шинжилгээ хийлгэсэн 36 хүн, биеийн бүрдмэл үзлэгт 28 хүн, ЭХО-д 28 хүн, элэг бүтэн /в,с вирус илрүүлэг/ шинжилгээг 46 хүнд хийж, 1 хүнд С вирус, 1 хүнд В вирус илэрсэн. зүрхний цахилгаан бичлэгт 26 хүн, хөхний үзлэгт 33 хүн, артерийн даралт хэмжихэд 58 хүн тус тус хамрагдсан бөгөөд өлөн үеийн цусны сахар 25 хүнд тодорхойлж, хэвийн хэмжээнээс их буюу /6,1-6,9/ анхаарах түвшинд -9 хүн байсан.

“ТЭМБҮҮГ УСГАЯ” аянг зохион байгууллаа: Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Ажлын хэсэг шинэчлэн батлах тухай” А/327, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын “Төлөвлөгөө батлах тухай” А/118 дугаар тушаалыг хэрэгжүүлж, Багануур дүүргийн эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны 8 сарын 20 “Тэмбүүг устгая” аян зохион байгуулах тухай А/41 тоот тушаал гарган хэрэгжүүлж байна. Уг тушаалаар аяныг зохион байгуулах удирдамж, ажлын хэсгийг томилж 8 заалт бүхий ажлын төлөвлөө гарган БЗДХ-ын кабинет, эмэгтэйчүүдийн кабинет, ӨЭМТ, ААНБ-тай хамтран хэрэгжүүлж байна. 2019 оны 10 сарын 30-ний байдлаар бэлгийн замаар дамжих халдварын кабинетад хийгдсэн нийт үзлэг 866, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг- 710 , өвчний учир-134, сайн дураар ирсэн- 24 байна. Тэмбүүгийн 10 шинэ тохиолдол илрүүлж 100% эмчилгээнд хамруулсан. Илрүүлсэн хавьтлын тоо-3, үзлэг шинжилгээнд хамруулсан 3, хавьтлаас шинээр илэрсэн тэмбүү-2 , эмчилгээнд хамруулсан 2 тохиолдол байна. ЭМТ жирэмсний кабинеттай нягт холбоотой ажилладаг ба 11 сарын байдлаар дүүргийн хэмжээнд төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй болно. Энэ хугацаанд 4 жирэмсэн эмэгтэй тэмбүү өвчтэй илэрсэн ба эмчилгээ бүрэн хийгдсэн.

Кабинетаар үйлчлүүлсэн 539 иргэдээс 144 хүнд БЗДХ өвчин тэмбүү өвчний талаар мэдээлэл хийж сургалт хийсэн Дүүргийн ЕБ 66 сургуулийн 8 ангийн 2 бүлгийн хөвгүүдэд Шилжилтын нас ба бэлгийн боловсрол сэдвээр сургалт хийсэн 20 сурагч хамрагдсан.

Г. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн НЭМ-ийн тусламж үйлчилгээ:

НЭМГ даргын 2019.04.08 өдрийн “Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дэмжих жил” болгох тухай А/55-р тушаалыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, эхний 5 сарын байдлаар биелэлт 85,2%-тай байна.

НҮЭМ-ийн НЭМ-ийн зохицуулагчийг 2019 оны 01 сараас орон тоогоор ажлуулж байгаа бөгөөд НЭМТөвд нөхөн үржихүй кабинетийг тохижуулж жирэмсэн эхчүүдэд 18 удаа сургалт хийж 184 эмэгтэйчүүдийг хамруулсан. Хүүхэд, өсвөр үе, залуучуудад НҮЭМ-н боловсрол олгоход анхаарч өсвөр үеийн кабинетийн эмчтэй хамтран сурагчдад 2 удаа сургалт явуулж 52 сурагч хамрагдаж, 42 охидод ганцаарчилсан зөвөлгөөг өгч ажиллалаа. Үр хөндөлтийн хор уршиг, хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх, аюултай үр хөндөлтийн талаар 2 цогцолбор сургуулийн ахлах ангийн 552 сурагчид оролцлоо.

Дүүргийн хэмжээнд үр хөндөлт-32 буюу 1000 амьд төрөлтөнд 118 байна. Өрхийн ЭМТөвүүд дээр очиж илүү өртөмтгий бүлгийн болон ажилгүй, эрүүл мэндийн даатгалгүй зэрэг эмзэг бүлгийн 194 эмэгтэйчүүдэд үзлэг хийж шаардлагатай эмэгтэйчүүдийг ЖСА-д хамруулж зөвлөгөө өгөв. ӨЭМТөвүүдтэй хамтран нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан урьдчилан сэргийлэх үзлэгийг 4 удаа зохион байгуулсан. Илүү өртөмтгий бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад онцгой анхаарч ЖСА-д 152 эмэгтэй буюу 69,2% хамруулсан.

Эмэгтэйчүүдийн кабинетад эх барих эмэгтэйчүүдийн эмч тогтвортой ажиллаж, ерөндөг-102, суулгац-6, тариа-140, эм-1112, бэлгэвч-365 тараасан. ЖСА-д хамрагдалтын хувь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 44.3%- г эзлэж байна. Энэ онд жирэмсний хяналтанд 297 эх хамрагдаж эрт илрэлт 88,1%. ЭМТөвийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд байдаг /групптэй/ НҮН эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж шаардлагатай хүмүүсийг 80,3%-г ЖСА-д хамруулан ажиллаж байна.

Дүүргийн хэмжээнд 14564 эмэгтэйчүүдээс Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд 7076 байна .НҮНЭ-дийн судалгааг гаргаж жил бүр шинэчлэн бүртгэж, үүнээс илүү өртөмтгий бүлгийн эмэгтэйчүүд 1045 байна.

Д. Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг сайжруулж, эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх:

Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүлжүүлэх ажлын хүрээнд 2019 онд

- Сүрьеэгүй дүүрэг дэд хөтөлбөр
- Сүрьеэгийн эрүүл зүйн кабинет нээн ажлуулах зэрэг ажлуудыг хийлээ.


Сүрьеэгийн эрүүл зүйн кабинетийг нээн ажиллуулж нийт 11206 хүнд үзлэг хийснээс Сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэг -7452, халдвартын урьдчилан сэргийлэх үзлэг-3774 байна.

“Сүрьеэгүй дүүрэг” дэд хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу ажлын хэсэг томилогдон 4 удаагийн уулзалт зохион байгуулж, хэлэлцүүлэг хийсэн ба ИТХурлаар 2 удаа, ДЗД-ын зөвлөлийн хурлаар 1 удаа хэлэлцэгдэж дэмжигдсэн.

Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019.06.05-ны өдрийн 03 тоот тогтоол, Засаг Даргын 2019.06.18- ний А /217 дугаар захирамжаар 2019.06.27 өдөр нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, дэмжин оролцсон бүх албан байгууллагуудад хөтөлбөрийг гардуулан хамтын ажиллагаанд амжилт хүссэн. Хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд нийт 26 байгууллагын 121 иргэд, ажилтан, албан хаагчид оролцсон.

Сүрьеэгийн эрт илрүүлэгийн үзлэгийг 11 байгууллагын 5-н хорооны нийт 4734 хүнд зохион байгуулсан.

Эрүүл Мэндийн Сайдын 2019 оны А/145 тоот тушаалын хүрээнд дүүргийн боловсролын байгууллагын багш, ажилчдыг сүрьеэгийн эрт илрүүлэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.



“Сүрьеэгүй дүүрэг” дэд хөтөлбөрийн хүрээнд “тогтвортой хөгжлийн эрин үед сүрьеэг устгах олон талт хамтын ажиллагаа” нөлөөллийн уулзалт хэлэлцүүлэг: “Сүрьеэгүй дүүрэг” дэд хөтөлбөрийн хүрээнд Глобал сантай хамтран “Тогтвортой хөгжлийн эрин үед сүрьеэг устгах олон талт хамтын ажиллагаа” нөлөөллийн уулзалт хэлэлцүүлэгийг дүүргийн хэмжээнд амжилттай зохион байгууллаад байна. Энэ арга хэмжээнд Нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын мэргэжилтэнүүд, ХӨСҮТ-ийн тандалт судалгааны алба, дүүргийн Нийгмийн Эрүүл Мэндийн Төв, Нийгмийн Хөгжлийн Хэлтэс, Боловсролын хэлтэс, Хороодын засаг дарга болон төлөөлөлүүд оролцож, сүрьеэ өвчний эрт илрүүлэгийн явц болон тулгамдсан асуудалыг ярилцаж хэлэлцлээ.

Е. ХДХВ, бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах чиглэлд:

Бэлгийн замаар дамжих халдварыг илрүүлэх нийт үзлэг-2969, үүний 84,2% нь урьдчилан сэргийлэх үзлэг, 544 иргэдэд сургалт зохион байгуулсан байна.

Ё. Хүүхэд өсвөр үеийн эрүүл мэндэд үзүүлэх НЭМ-ийн тусламж үйлчилгээ:

Өсвөр үеийн кабинет нь ӨЭМТ-ийн болон ЕБС-ийн эмч нартай хамтран ЭМ-ийн чиглэлээр мэдээлэл сургалт хийх, урьдчилан сэргийлэх үзлэг хийж зөвлөгөө өгөх, эрсдэлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдэд ганцаарчилсан зөвлөгөө өгөх,

гэр бүлд нь холбон зуучлах зэргээр ажиллаж байна. Нийт үзлэг 2198, үүний 51,9 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг, ганцаарчилсан зөвлөгөө өгсөн өсвөр насны хүүхэд-98 нийт 1496 хүнд үйлчилгээ үзүүлж ажилласан.

Хүүхдийн тусламж үйлчилгээний хяналт үнэлгээг тогтмолжуулан, хүүхдийн эрүүл мэндийн судалгаануудыг хийж дүгнэлттэй ажиллахад дүүргийн нийт өсвөр насны хүүхдийн тоо 4441 /10-18нас/, Сургуульд сурдаг 6050, Хөдөлмөр эрхэлдэг 21/ унаач хүүхэд/, Сургууль завсардсан 1 /аутизм 4-р ангиас/, Хэвтрийн 14, Нэн ядуу 1253, Жин багатай 106, Илүүдэл жинтэй 291, Таргалалттай 66, Өсөлт хоцорсон 85, Хагас өнчин, 163, Бүтэн өнчин 16, Айлд суудаг 419, Эмзэг бүлгийн /Эрсдэлт / 121 байна.

2019 оны хагас жилийн байдлаар ЭМТ-ийн хүүхдийн тасагт 726 хүүхэд хэвтэн эмчлүүлсний 131 нь буюу 18.0% нь өсвөр насныхан эзэлж байна. Охидын төрөлт нийт төрөлтийн 5.7%-г эзэлж байна. Өсвөр үеийнхний бэлгийн замаар дамжих халдвараар өвдөж оношлогдсон байдал 2019 оны хагас жилийн байдлаар нийт тохиолдлын 10.9%-г эзэлж байна. ЕБС-д суралцаж байгаа нийт 81 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

Ж. Сэтгэц наркологийн тусламж үйлчилгээ:

Сэтгэц наркологийн кабинет нь 2019 онд нийт 3429 хүнд үзлэг хийснээс өвчний учир 1141, урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 66,7% байна.

Органик шалтгаант сэтгэцийн хурц өөрчлөлттэй 8 хүнийг стационарт хэвтүүлэн эмчилж ремисс-н байдалд оруулан, хурц солиоролтой догшролтой 21 хүнийг ар гэр болон цагдаагийн тусламжтай СЭМҮТ-д хүргэн гараас гарт хүлээлгэн өгч дүүргийн хүн амд үзүүлэх аюултай үйлдлээс сэргийлж эмчилгээнд оруулсан.

Өсвөр үеийн кабинет, сэтгэл зүйч, хорооны нийгмийн ажилтантай хамтран төрх, сэтгэцийн хурц догшролтой солиоролтой 34 хүнийг цагдаагийн тусламжтай СЭМҮТ-д хүргэн эмчилгээнд оруулж нийгэмд аюултай үйлдэлээс /өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах/ хамгаалсан байна.

Өдрийн архины хордлого тайлах эмчилгээнд 18 хүнийг хамруулан диспансерын хяналтанд авч ар гэртэй нь холбоотой ажиллаж байна.

Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээний кабинет"-аар сэтгэцийн өвчний учир хяналтанд байдаг үйлчлүүлэгчдийг 5 бүлэгт хуваан сэтгэцийн сувилагч нь МАНДАЛА зураг будуулж бүтээл хийлгэн, 26 хүнд зургийн эмчилгээ хийсэн. Ингэснээр тэд өөрсдөө зураг зурж, зураг будаж бүтээл хийснээрээ сэтгэл нь тайвширч урамшин, сэтгэхүй нь сайжрах,



бусад чадварууд нөхөн сэргээгдэх үр дүнтэй байдал харагдаж байна.

Сэтгэцийн эмч нь 2019 онд Дүүргийн Цагдаагийн Хэлтэсээс шинжээч эмчээр томилсон томилгооны дагуу 18 хүнд сэтгэцийн тусгай үзлэг, шинжилгээ хийсэн.

Хэрэг хариуцах чадвартай эсэх *Шүүх сэтгэцийн дүгнэлт*-ийг гарган мөрдөн байцаагчид заасан хугацаанд нь хүргэн ажиллав.

3. Дархлаажуулалт:

Дархлаажуулалтын цахим бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. ӨЭМТ-үүд нь 15 хүртэлх насны заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан 496 хүүхдийн мэдээллийг цахим бүртгэн оруулж байна. ЭМТ-ийн төрөх тасагт регистерын дугаар олгож эхэлсэнтэй холбоотой төрсний дараах 24 цагийн дотор дархлаажуулалтанд хамрагдсан хүүхэд бүрийн мэдээллийг бүртгэж байна. Одоогоор 203 хүүхэд бүртгэсэн. Вакцин биобэлдмэлийн нөөц , хангамжийн VSSM 4.7 программыг 2019 оны 1 сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.

ЭМЯ-ны захиалгаар ХӨСҮТ, НЭМҮТ-ийн хамтарсан “Тарилгатай халдварт өвчний дархлал тогтоцын түвшинг судлах ” судалгаанд нийт 60 өрхийн 108 хүн хамрагдсан.

Дархлаажуулалтын цахим бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. ӨЭМТ-үүд нь 15 хүртэлх насны заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан 1963 хүүхдийн мэдээллийг цахим программд бүртгэсэн. ЭМТ-ийн төрөх тасагт регистерын дугаар олгож эхэлсэнтэй холбоотой төрсний дараах 24 цагийн дотор дархлаажуулалтанд хамрагдсан хүүхэд бүрийн мэдээллийг бүртгэж байна. Одоогоор 463 хүүхэд бүртгэсэн.

Вакцин биобэлдмэлийн нөөц , хангамжийн VSSM 4.7 программыг 2019 оны 1 сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.

ӨЭМТ-үүдэд дархлаажуулалтын нэгж нээн ажиллуулахад шаардагдах хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн захиалгыг ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албанд хүргүүлсэн.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 10 сарын 03-ны өдрийн А/451 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны 10 сарын 04-ны өдрийн А/477 дугаар тушаалаар Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулсан. Улирлын томуугийн эсрэг вакцинд эрсдэлт бүлгийн архаг хууч өвчтэй, 65 дээш насны 600 хүн, эмч, эмнэлгийн мэргэжилтэн 450 хүн, дүүргийн 9 цэцэрлэгийн нийт 2060 хүүхэд хамрагдсан.

2019 оны эхний 10 сарын байдлаар заавал хийх дархлаажуулалтанд БЦЖ-100%, Халдварт саа-97%, Тавт-96.5%, Гепатит А-92%, УГУ-92%, Гепатит В-100%, ПЭВ-94.6% хамрагдсан. Дархлаажуулалтын нэгжүүдийн үйл ажиллагаанд , хүйтэн хэлхээний горимыг чанд мөрдөн ажиллаж байгаа эсэхэд халдвар судлагч өдөр бүр тогтмол хяналт тавьж ажилласан. НЭМГ-ын даргын А/49 дугаар тушаалын дагуу 2019 оны 04 сарын 18-ны өдөр НЭМГ-ын мэргэжилтэн Ж.Энхцэцэг, Э.Энхжаргал нар дэмжлэгт хяналт хийж, хяналтаар дархлаажуулалт хийх явцад илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан.

ЭМС-ын А/207 дугаар тушаал, НЭМГ-ын А/71 дүгээр тушаал, Багануур дүүргийн засаг даргын А/152 дугаар захирамжийг үндэслэн БНДЭМТ-ийн даргын А/22 дугаар тушаалын дагуу дархлаажуулалтын 10 хоногийг 2019.05.15-ны өдрөөс 2019.05.25-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Дархлаажуулалтын 10 хоногоор заавал хийх товлолын дархлаажуулалтаас хоцорсон хүүхдүүдийг нөхөн

дархлаажуулж, 10-18 насны хүүхдүүдийг Улаанбурхан Улаануудын эсрэг вакцинаар дархлаажуулсан. Нийт 3773 хүүхэд вакцинд хамрагдаж, хамралтын хувь 96% байна. 2019 оны 05 сарын 08-ны өдөр НЭМОДарга, халдвар судлагч, бага эмч нар Дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулах үндэсний сургалтанд хамрагдсан. Мөн дархлаажуулалтын 10 хоногоор нэмэлтээр дайчлагдан ажиллах 14 сувилагчийг сургалтанд хамруулсан. Дархлаажуулалтын 10 хоногийг угтан 2019 оны 05 сарын 09-ны өдөр НЭМТөвийн сургалтын зааланд дүүргийн МСҮТ, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтан нарт Улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтын зохион байгуулалтын талаархи сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд нийт 13 хүн хамрагдсан. Мөн 2019 оны 05 сарын 14-ны өдөр Улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтанд ажиллах ЭМТ болон ӨЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн эмч нарт сургалт зохион байгуулж, нийт 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.

Л. Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг: Тайлант хугацаанд 169 хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж хүн тус бүрд зөвлөгөө өгч, урьдчилан сэргийлэх сийлант-7, цоорлын явцыг удаашруулах түрхлэг-16, фторт лак-15 хүүхдэд түрхэн, нийт 1518 хүүхдэд сургалт зохион байгуулсан байна.

Эрүүл шүд эрүүл хүүхэд хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад дүүргийн Да экюпмент шүдний эмнэлэг шалгаран 05 сарын 01-ний өдрөөс эхлэн үзлэг, эрүүлжилтийн ажлыг эхлүүлж нийт 86 хүүхдэд үзлэг хийж, эрүүлжилтийн хувь 17,4% /15/ байна. Уг хөтөлбөрийн хүрээнд ЭМТ-ийн зүгээс Да экюпмент шүдний эмнэлгийн багажны ариутгалын төлбөрийг 23%-иар хөнгөлөн ажиллаж байна.

3.2 ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

А. Эмчилгээ, үйлчилгээний чиглэлээр

Хөнгөвчлөх эмчилгээний тусламж үйлчилгээг НЭМГ-ын даргын 2017 оны



а/0 тушаалаар Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний орыг дотрын хөнгөвчлөх эмчилгээний 4, хавдарын үеийн хөнгөвчлөх эмчилгээний 4, нийт 8 болгон нэмэгдүүлэн батлуулж, 2018 оны 1-р улирлаас Халдвартын тасгийн ашиглагдахгүй байсан 300

гаруй м/кв 6 ерөө

бүхий талбайд Багануур ХК-ний Уулын 2-р хэсгийн экскаваторын хамт олны зүгээс сайн үйлсийн аяны хүрээнд иж бүрэн засвар тохижилт хийлгэн үйл ажиллагааг нь өргөжүүлэн ажлуулж эхэлсэн. Хөнгөвчлөх эмчилгээний тасаг нь нарийн мэргэжлийн 1 их



эмч, хөнгөвчлөх эмчилгээний өдрийн 1 сувилагчтайгаар 2019 онд 219 хүнийг 1465 ор хоногт хэвтүүлэн эмчилж үйлчилсэн байна.

Гемодиализ эмчилгээ: 2019 оны 04 сарын 30-нд өөрийн хөрөнгөөр Гемодиализийн эмчилгээний NCU-18 загварын 1ш аппарат нэмж аван, 3ш аппараттайгаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд тайлант хугацаанд 15 хүнд 1063 сеанс эмчилгээг хийгээд байна. 2018 онд сард дээд тал нь 125 сеанс эмчилгээ хийх хүчин чадалтай байсан бол 2019 онд 180 сеанс эмчилгээ хийх хүчин чадалтай бол хүртээмж нь нэмэгдсэн. Үүний үр дүнд дүүргийн төдийгүй хил залгаа сумд болох Мөнгөнморьт, Баяндэлгэр, Цэнхэрмандал сумын нэн яаралтай болон төлөвлөгөөт эмчилгээг хийж байна.



НЭМГ-ын даргын 2019 оны “Эмнэлгийн тусламж, үйлчилгээг шинэчлэн зохион байгуулах, өргөжүүлэх тухай” А/59 тоот тушаалын дагуу **2019 онд мэс засал, гэмтлийн тусламж үйлчилгээг орон нутагт хөгжүүлэх** зорилгоор Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 115 сая.төг бүхий C-RAM гэмтлийн мэс заслын үеийн дижитал рентген аппарат, дунд чөмөгний гэмтлийн ком багаж, доод мөчний гэмтлийн ком багаж, шилбэний гэмтлийн ком багаж, дээд мөчний гэмтлийн ком багажнуудтай болсоны үр дүнд 2019 онд гэмтлийн 18 төрлийн 64 удаагийн мэс заслыг амжилттай хийсээд байна. Энэ нь тусламж үйлчилгээг иргэдэд цаг алдахгүй үзүүлэх, УБ хот руу явах урсгалыг багасгах, үйлчлүүлэгчдийн цаг хугацаа, эдийн засгийг хэмнэх зэрэг ач холбогдолтой иргэдийн талархал хүлээсэн үйлчилгээ болоод байна.

Шинээр хийгдэж буй гэмтлийн мэс заслууд:

1. Дунд чөмөгний хугарлыг ил аргаар ялтас шургаар бэхлэх мэс засал
2. Шилбэний хугарлыг хагас ил аргаар түгжээт хадаасаар бэхлэх мэс засал
3. Шивнүүрийн хугарал ил аргаар бэхлэх мэс засал
4. Сорви чөлөөлж, арьс нөхөх мэс засал



5. Гарын хуруу болон хөлийн борвины шөрмөс залгах хагалгаа
6. Гадна хавчаар ясны хугарлыг /шагай/ ил аргаар бэхлэх мэс засал
7. Шууны хугарлыг ил аргаар ялтас шургаар бэхлэх мэс засал
8. Шилбэнээс хадаас авах мэс засал
9. Шуунаас уян хадаас авах мэс засал
10. Гарын долоовор хурууны тэнийлгэгч шөрмөс залгах мэс засал
11. Борвины шөрмөс залгах мэс засал
12. Шагайн үений хагас мултралыг засч, гадна хавчаар ясны хугарлыг ил аргаар эвлүүлж ялтас шургаар бэхлэх мэс засал
13. Шаант ясны доод булууны үе дайрсан хоёрлосон хугарал, гадна хавчаар ясны зөрөөтэй хугарлыг ил аргаар эвлүүлж ялтас шургаар бэхлэх мэс засал
14. Хүүхдийн шуу, богтос ясны гандан хэсгийн хавсарсан хугарлыг рентген харалтын доор эвлүүлж, далд аргаар уян хадаасаар бэхлэх мэс засал
15. Эгэмний сэлтэрч зөрсөн хугарлыг ил аргаар эвлүүлж ялтас шургаар бэхлэх мэс засал
16. Өвдөгний үе солих мэс засал
17. Дунд чөмөгний хугарлыг рентген харалтын дор эвлүүлж, түгжээт хадаасаар бэхлэх мэс засал
18. Цээж, хэвлийн гэмтлийн үеийн мэс засал

Анатомын бүрэн бүтэн байдлыг богино хугацаанд сэргээж, хагалгааны дараахь 1 дэх өдрөөс хөдөлгөөн хийх боломжтой болох бөгөөд хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг 50%-иар бууруулан, эмнэлгийн ор хоногийг 4-5 хоногоор бууруулж чадсан.

Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг буюу 3-р шатлалын эмнэлэгийн ачааллыг багасгасан, дүүргийн иргэдийнхээ орон нутагтаа эмчлүүлэх бололцоог бий болгон тусламж үйлчилгээний нэр төрөл олширч, эмч нарын мэргэжлийн ур чадвар дээшилж, санхүүгийн хэмнэлтийг бий болгож байна.

Уг тусламж үйлчилгээ нь НЭМГ-ын хэмжээнд зохион байгуулсан “Сайн туршлага-2019” арга хэмжээнээс “Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний технологи”-иор Тэргүүн байр эзэлсэн.



Мэдээгүйжүүлгийн их эмч Г.Азбаяр 2018 оны 10 сард хүүхдийн мэдээгүйжүүлгээр төрөлжсөн нарийн мэргэжил олгох сургалтанд хамрагдан төгсч, 2019 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн мэс заслын багажтай болсны үр дүнд **хүүхдийн мэдээгүйжүүлэг, хүүхдийн мэс заслыг орон нутагтаа** хийх боломж бүрдсэн бөгөөд 2019 онд 10 хүртлэх насны хүүхдэд тохиолдсон 5 төрлийн 54 удаагийн мэс заслыг орон нутагтаа хийж байна. Үүнд:



- Цавины ивэрхий
- Фимоз
- Гэдэсний үхжилт үрэвсэл
- Гэдэсний түгжрэл
- Хүйсний ивэрхий
- Төмсөг буулгах
- Мухар олгой зэрэг тусламжуудыг

үзүүлдэг болоод байна.

Одоо хүүхдийн мэс заслын эмчийн нарийн мэргэжил олгох сургалтанд мэс заслын их эмч Б.Батзаяа суралцаж байгаа учир хүүхдийн мэс заслын тусламж үйлчилгээ орон нутагт улам өргөжин хөгжих боломж бүрдэж байна. Хүүхдийн мэдээгүйжүүлэг ба хүүхдийн мэс заслын нарийн мэргэжлийн эмч нарыг бэлтгэснээр хүүхдийн мэдээгүйжүүлгийг хийж, 53 удаагийн мэс заслыг амжилттай хийсэн бөгөөд 2019 онд ЭХЭМҮТ-ийн хүүхдийн мэс заслын эмч нартай хамтран нярайн 2 удаагийн мэс заслыг хийсэн.

“Хэвлийн дурангийн аргаар цөсний хүүдий авах мэс засал”: 2015 оноос эхлэн дүүргийн эмнэлгүүдээс анхдагчаар Америкийн нэгдсэн улсын Дурангийн мэс заслын эмч нарын холбоо, Америкийн нэгдсэн улсын Ютай Анагаахын Их сургуулийн харъяа Глобал мэс заслын төв, Монголын Дурангийн мэс заслын эмч нарын холбоо, Солонгос улсын мэргэшсэн эмч нар, Солонгос улсын “Gangneung Asan hospital” эмнэлгийн профессор Choi Kum Moo –гаар ахлуулсан мэс заслын баг, Монголын Дурангийн мэс заслын эмч нарын холбоотой хамтран хэвлийн хөндийн дурангийн мэс заслын тусламжийг орон нутагтаа хийж эхэлсэн.

Хэвлийн дурангийн аргаар цөсний хүүдий авах бүх хагалгааг 2018 оны 11 сараас эхлэн мэс заслын их эмч Л.Ихбаяр төрөлжсөн нарийн мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтанд хамрагдан төгсч ирснээр орон нутагт бие даан хийж эхэлсэн. Энэ хугацаанд нийт 24 хагалгааг хийгээд байгаа бөгөөд бүх хагалгааг 3 трокарын хүрцээр хийсэн нь 1 трокарын зардал хэмнэсэн хагалгааны явцын хурдыг нэмэгдүүлсэн үр дүнтэй байна. Хэвлийн дурангийн аргаар цөсний хүүдий авах мэс засал нь нээлттэй аргаар хийгдэх мэс заслаас өвдөлт бага, гоо сайхны хувьд сорив бага, хөдөлмөрийн чадвар түргэн сэргэдэг эдийн засгийн хувьд зардал хэмнэх зэрэг олон давуу талтай бөгөөд эмнэлгийн талаас ажиглахад хэвтэн эмчлүүлэх ор хоног 5-6 хоногоор цөөрсөн. Мөн цочмог идээлсэн цөсний хүүдий авах мэс заслын үед шархны халдварлах хүндрэл гараагүй сайн талтай байна.



Хэт авиан оношилгооны тусламжтайгаар төвийн венийн судсанд гуурс тавих ажилбарыг нэвтрүүлсэн. Уг ажилбарыг нэвтрүүлснээр үйлчлүүлэгчид аюулгүй, эрсдэлгүй, хүндрэлгүй /олон дахин хатгагдах, зэргэлдээх эрхтэн, артер хатгагдах, цус алдах зэрэг/ тусламж үйлчилгээ үзүүлж байна.



“Метотрексат эмчилгээ”: Метотрексат эмчилгээг хийснээр мэс заслын эрсдлийг бууруулах бүрэн боломжтой юм. Умайн гаднах жирэмсний зарим тохиолдлыг мэс заслын бус аргаар шийдвэрлэх боломжтой бөгөөд урьд өмнө бүх тохиолдлыг мэс заслын аргаар эмчилдэг байсан бол 2019 онд 6 тохиолдолд энэ аргыг хэрэглэж үр дүнтэй болсон. Цаашид энэ эмчилгээг тогтмол үргэлжлүүлснээр яаралтай мэс заслын тоо, эрсдлийг бууруулах бүрэн боломжтой гэж үзэж байна.



“Фоли катетераар умайн хүзүүг төрөлтөнд бэлтгэх”: Умайн хүзүүний нээлт багатай эхэд тамедины уусмалаар угаалга хийж үтрээгээр нь /18-20G/

хэмжээтэй фоли катетерийг умайн хүзүүнд оруулан дотор хэсэгт нь 70 мл физиологийн уусмалыг хийлж 8 цаг байлгаад авна. Өндөр эрсдэлтэй мезопростол



эмийн оронд фоли катетерийг хэрэглэх нь умай ургадахыг завдах эрсдэл үүсэхгүй ач холбогдолтой. **Уг тусламж үйлчилгээг** 2019 оны 7 сараас нэвтрүүлж эхэлсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 11 хүнд фоли катетер тавьсан. Бүгд эрсдэлгүй умай хүзүү төрөлтөнд бэлтгэгдсэн байв. Үр дүн 100%.

Угтах, цахим үйлчилгээ иргэдэд улам ойртсоор: Дүүргийн иргэд өөрийн харьяа ӨЭМТ-өөсөө дүүргийн ЭМТ-ийн нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх цаг авах боломжийг бүрдүүлсэн ба УНТЭ-тэй харилцан хамтран ажиллах хэлэлцээр байгуулсны үр дүнд дүүргийн ЭМТ-өөс 13а маягтаар УНТЭ-ийн нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх цагаа авах боломжтой болж үйлчлүүлэгчдийн чирэгдлийг багасгасан.

Амбулаторийн хэсгийн 2 жигүүрт 4 хөтөч сувилагчийг тогтмол ажиллуулж

- Шинжилгээний бар кодыг шууд олгох
- Үйлчлүүлэгчдийн артерийн даралт үзэж, пульс тоолох
- Биеийн жингийн индекс тодорхойлох
- Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хийх зэрэг сувилахуйн тусламжийг үзүүлэн ажилласнаар иргэдэд үйлчилгээ ойртуулж, төвлөрлийг сааруулж байна.



Өдрийн хими эмчилгээ хийхээс гадна 48 цагийн хими эмчилгээг орон нутагтаа хийж байна. Хавдрын эсрэг өвөрмөц эмчилгээ болох хими эмчилгээг УБ хот, Хавдар судлалын үндэсний төвд очин хийлгэдэг байсан бол 2017 оны 06 дугаар сарын 14-ны өдрөөс орон нутагтаа хийж эхлэн.

- 2017 онд 3 хүн 2 назологиар схемийн дагуу 15 удаагийн өдрийн хими эмчилгээ
- 2018 онд 16 хүнд 7 назологиар схемийн дагуу 63 удаагийн өдрийн хими эмчилгээ, 48 цагийн хими эмчилгээг нэмэгдүүлэн нэвтрүүлж 1 хүнд схемийн дагуу 11 удаагийн эмчилгээ
- 2019 онд 56 удаагийн хими эмчилгээ нийт 27 хүнд 8 төрлийн өвчний назологиар хийсэн. Үүнээс 13 удаа 48 цагийн хими эмчилгээг хийж үйлчилсэн.

Хими эмчилгээнд хамрагдагсдын өвчний назологын байдал 2017 онд өндгөвч, хөхний хавдар, 2018 оноос ходоод, улаан хоолой, давсаг, умайн хүзүү, хамар залгиур, 2019 онд уушгины хавдарын үеийн хими эмчилгээнүүд тус тус нэмэгдсэн. 2017 оны 05 сараас хойш 2 жилийн хугацаанд хими эмчилгээнд орсон бүх эмчлүүлэгч нар дахилт, сэдрэл өгөөгүй, хүндрэл гараагүй байгаа нь эмчилгээний үр дүн сайн болохыг харуулж байна.

2016-2017 онд ЭМСХХ-5 төслийн хүрээнд **Цусны салбар банк**ийг **өргөжүүлэх төслийн хүрээнд** нийт 51 нэр төрлийн 72 ширхэг 732950031,31₮ нийт тоног төхөөрөмж, тавилга, багаж, хэрэгсэл, урвалж бодис, 50 сая.төг-ний байрны засвар үйлчилгээ хийгдэж, сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангагдсаны үр дүнд 4-6 нэр төрлийн цус цусан бүтээгдэхүүнийг 1-3 цагийн хугацаанд орон нутагтаа үйлдвэрлэн, эмчилгээ үйлчилгээнд хэрэглэж байна. Үүний үр дүнд:

- Цус цусан бүтээгдэхүүнийг
- Яаралтай үеийн бэлэн байдал хангагдсан.

Цусны салбар банк нь жилд дундажаар 200 орчим донороос бүхэл цус цуглуулж 100000 орчим мл 400 орчим нэгж 4-6 нэр төрлийн цус цусан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, хэрэглэж байна.

Тайлант хугацаанд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний төрөл болон нөөцийн байдал:

- Даршилсан улаан эс 62763 мл буюу 241 нэгж
- Хөлдөөсөн шинэ сийвэн 51173 мл буюу 236 нэгж
- Криопредципитат 195 мл буюу 13 нэгж
- К сийвэн 2425 мл буюу 13 нэгж
- Улаан эсийн өтгөрүүлэг 1702 мл буюу 14 нэгж
- Ялтаст эсийн өтгөрүүлэг 750 мл буюу 15 нэгж нийт 6 нэр төрлийн 119008 мл 532 нэгж цус цусан бүтээгдэхүүн байна.

БНСУ-ын Philips компани болон СВМС төрийн бус байгууллагын хандиваар 32 сая төгрөгийн өртөг бүхий **Чих хамар хоолойн өвчний үзлэг, оношлогоо, эмчилгээ**ний өнгөт дэлгэцийн аппарат, ЧХХ өвчний эмчилгээний утлага, шарлага, тимпано массажийн аппаратыг 2018 оны 9-р сарын 10-нд хүлээн авч, нийт 17932 хүнд үзлэг, давхардсан тоогоор 37657 хүнд эмчилгээ хийсэн байна. Уг аппарат нь эмчилгээ, оношлогооны дараах дэвшилтэт ач холбогдолтой байна. Үүнд:

- ✓ Гүйлсэн булчирхайд шигдсэн гадны биет авах
- ✓ Хэнгэрэгийн цоорлын хэмжээ, хэлбэрийг оношлох
- ✓ Төвөнх болон залгиурын хэсэг газрын эмчилгээ хийх

2018-2019 онд ЭМСХХ-5 төслийн хүрээнд:

- **хог хаягдалын менежментийг сайжруулах** 1,725,487,400₮,
- **микробиологийн лабораторийн үйл ажиллагааг сайжруулах** 3,927,532,143.99₮,
- **эмнэлгийн ариутгалын менежментийг сайжруулах** 6,847,156,674.24₮, нийт 12,721,537,756.23₮-ний санхүүжилт бүхий төсөл хэрэгжиж байгаа бөгөөд 2019 оны 06 сарын 01-ны өдрөөс микробиологийн лаборатори, 2019 оны 08 сарын 01-ны өдрөөс төвлөрсөн ариутгалын хэсэг тус тус ажиллаж эхэлсэн.

Үүний үр дүнд:

- Үйлчлүүлэгчид, иргэдийн антибиотик тэсвэржилт буурах
- Сүүлийн жилүүдэд антибиотикийн хэрэглээ, зөв сонголтонд эерэгээр нөлөө үзүүлэх

- Эмнэлгийн дотоод халдварыг тандах судлах сэргийлэх үйл ажиллагаа сайжирах
- Эмнэлгийн халдвар хамгааллын дэглэм сайжирч, эрсдэл буурах зэрэг өндөр ач холбогдолуудтай.



Тайлант хугацаанд төвлөрсөн ариутгалын хэсэг нь **аннио септ актив** ариутгалын уусмалаар нийт 187459 ширхэг багаж, 8357 бикс, 40кг хөвөн, марль, бинт ариутгасан материал бэлтгэн эмнэлгийн тусламж үйлчилгээнд нийлүүлсэн.

ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар ОХУ-д үйлдвэрлэгдсэн ВФЭ2/0.9 маркын Нэг удаагийн оролтонд 35 кг зөөлөн эдлэлийг ариутгах хүчин чадал бүхий 17,060,000 төгрөгийн дизкамерыг суурилуулж 2019.10.15-аас ашиглаж эхэллээ.

Хуучин /1985 онд үйлдвэрлэгдсэн/ ба шинэ дизкамер



Нийслэлийн Эрүүл мэндийн газраас 2019 оныг “Эх хүүхдийг тусламж, үйлчилгээг дэмжих жил” болгон зарласан. Энэ ажлын хүрээнд “**Жирэмсний хяналт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэг цэгийн үйлчилгээ**”-г ЭМТ-ийн амбулаторийн нэг давхарт байгуулан, жирэмсний зөвөлгөө өгөх кабинет, ЭХО болон лабораторийн шинжилгээ, сургалт суратлчилгаа, дугаар олголтын хэсгийг нэг цэгт төвлөрүүлсэн. Ингэснээр жирэмсэн эх, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэг дороос хүлээгдэл чирэгдэлгүй, чанар хүртээмжтэй, ээлтэй орчинд цогц байдлаар үзүүлэх нөхцөл бүрдэж байгаа юм.



Тайлант хугацаанд жирэмсний хяналтанд 660 эмэгтэй орсноос 568 эмэгтэй эрт хугацаандаа хамрагдаж, жирэмсний эрт илрүүлэлт 86,06 хувьтай байна. Эрхтэн тогтолцооны эмгэгтэй 315 эмэгтэйг бүртгэн авч, эмчилгээнд хамруулж байгаа бөгөөд эрүүлжилт 92,0 хувьтай байна. Жирэмсний пренаталь оношлогоонд рисктэй 122 эхийг хамруулсан. TORCH шинжилгээнд 24 эхийг хамруулж, архаг халдвартай 17 эх эмчилгээнд хамрагдсан. Онцгой хяналтанд 68 эхийг авч хянаж байгаагаас ЭХЭМҮТ–д 13 эхийг шилжүүлэн төрөлтийг шийдвэрлүүлсэн. Элэгний вирустэй 42 жирэмсэн эхчүүдийг нарийн мэргэжлийн эмч нартай хамтран хяналтыг хийсэн /В вирус-15, С вирус-15, хавсарсан вирус-5/. Эмэгтэйчүүдийн кабинетаар эсийн шинжилгээ-641, эдийн шинжилгээ-64, үтрээний наац-2448, өсгөвөр-68 авсан. LEEP эмчилгээ 2 тохиолдол хийсэн.



“МЭДРЭЛ, УЛАМЖЛАЛТ, СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГ”: Үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ, эмчилгээ оношлогооны практикт тулгуурлан уламжлалт анагаах ухаан болон европ эмчилгээний үр дүнтэй аргуудыг цогц




байдлаар хослуулан эмчлэх “МЭДРЭЛ, УЛАМЖЛАЛТ, СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГ”-ийг 26 ортойгоор 2018.02.01-ны өдрөөс нээн ажиллуулж эхэлсэн бол 2019 онд 8 ор нэмж 34 ортойгоор үйл ажиллагаагаа өргөжүүлэн 2018 онд 1290 хүн, 2019 оны эхний 11 сарын байдлаар 1192 хүн 8275 ор хоног ашиглан хэвтэн эмчлүүлээд байна.


Мэдрэл сэргээн засах эмчилгээний тасгийн орнч тоог нэмэгдүүлснээр хүлээгдлийн дундаж хугацаа 27 хоног байсан бол 6 хоног болж буурсан.

Уг хэвтүүлэн эмчлэх ортой тасаг нь дүүргүүдийн эмнэлгүүдийн дундаа анхдагчаар байгуулагдаж байгаа бөгөөд үйлчлүүлэгчдийн сэтгэлд хүрсэн тусламж үйлчилгээний нэг болоод байгаа төдийгүй Уламжлалт, сэргээн засах эмчилгээний эмч, мэргэжилтнүүд үйлчлүүлэгчидийн сэтгэлд хүрсэн, үр дүн сайтай шинэлэг тусламж үйлчилгээг нэвтрүүлсээр байна. **Үүнд:**

- **“Мэдрэлийн зүү /Neuro-Acupuncture/ эмчилгээ:** Энэхүү зүү эмчилгээ нь бусад их биеийн зүүг бодвол үйлчлүүлэгч зүүг тавиулсан байх хугацаандаа хөдөлгөөн дасгал болон бусад энгийн өдөр тутмын үйл ажиллагаа хийхэд ямар нэгэн саадгүйгээс гадна долоо хоногт 2-3 удаа л хийхэд үр дүн маш сайтай үйлчлүүлэгчийн цаг завийг хэмнэх юм. Мөн түүнчлэн хөдөлгөөн засал эмчилгээтэй хавсран хийснээр хурдан хугацаанд хүссэн үр дүнд хүрч байна.



- **“Хурууны үений хөдөлгөөн сайжруулах хавчаар”**: Бэртэл, гэмтэл, харвалт, саажилтын үед үены далайц хязгаарлагдаж хүч буурдаг. Иймээс гарны жижиг үений, булчингийн хүч үений далайцыг сайжруулахын тулд хавчаарыг ашиглаж дасгал хийлгэнэ.



- **“Шагай ээтийлгэх сойлт”**: Шилбэний арын булчингийн богиносолтын үед өлмийдөж алхах ба улаар гүйцэд тавигдаж алхахад бэрхшээлтэй болдог. Иймээс шагай ээтийлгэх сойлт нь хөлийг тавхайгаар бүрэн тавихад дэмжлэг үзүүлнэ.




- **“Сунгалтын тавцан”**: Нуруу ба өвдөгний үений өвдөлтийн үед гуяны арын болон эрээн булчин чангарч өвдөлт үүсдэг. Булчингийн чангаралыг арилгахын тулд сунгалт хийх нь илүү үр дүнтэй байдаг



- **“Төөнүүр эмчилгээний хэрэгсэл /төөнүүрийн хайрцаг 3 ширхэг/**: Төөнүүр эмчилгээ хийгдэж байх үед эмчийн ажлыг хөнгөвчлөх, цаг хэмнэх, эмчийн гар халах, арьс салст түлэгдэхээс урьдчилан сэргийлэх
- **“Ахуй засал” өрөө**: ЭМТ-ийн УСЗЭ-ний тасагт ахуй заслын өрөөгүй, ХБИргэд болон хүүхдүүдийн өдөр тутмын үйл ажиллагаа алдагдсан тохиолдол олон байдаг. Саа, саажилттай үйлчлүүлэгчдийн гар хөл үе мөчдын хөдөлгөөнийг сайжруулах тухтай таатай орчинг бүрдүүлж тухайн үйлчлүүлэгчид тохирсон хэрэгсэл дээр ажиллаж өдөр тутмын үйл ажиллагаа сэргээх зорилгоор **“Ахуй засал” өрөөг** шинээр тохижуулж нээсэн.



- **“Хөдөлгөөн засал кабинет”**: Тулгуур эрхтэний хөдөлгөөн хязгаарлагдсан, цус харвалтын дараах үлдэц саа саажилт, бэртэл гэмтэлтэй үйлчлүүлэгчдийн гар хөл үе мөчдын хөдөлгөөний далайцыг нэмэгдүүлэх үүднээс тухайн үйлчлүүлэгчид тохирсон хэрэгсэл дээр ажиллаж өдөр дутмын идэвхитэй үйл ажиллагаа сэргээх зорилгоор **“Хөдөлгөөн засал кабинет”**-ыг нээж ажилд оруулсан.



- **“БАЛЛОНТ ДУСЛЫН ШАХУУРГА”**: Богино хугацаанд үр дүнтэй шингэн сэлбэх шаардлага олон гардаг. Хоол боловсруулах замын их хэмжээний цус алдалт, бөөлжилт, суулгалт зэргийн үед богино хугацаанд их хэмжээний шингэнийг юүлэх зорилгоор ашиглаж байна. Дотрын тасагт цус алдсан 5 өвчтөнд их хэмжээний шингэнг богино хугацаанд /1 цагийн дотор 2литр/ үр дүнтэй сэлбэж гэнэтийн нас баралтаас сэргийлж чадсан.
- NIPRO NCU-18 маркийн Гемодиализын аппаратын тоог нэгээр нэмэгдүүлсэн бөгөөд БНЭМТ-р үйлчлүүлдэг 16 өвчтөний бөөрний архаг дутагдалын эмчилгээ хяналт сайжирсан. Аливаа өвчний улмаас үүссэн бөөрний хурц дутагдалтай 5 өвчтөний эмчилгээг цаг алдалгүй хийж тусламж үзүүлж амь насыг аварсан байна.





- **Эмгүйгээр халуун бууруулах иж бүрдэл**: Хатгалтын тоог цөөрүүлж, эм тарианы хэмнэлт гаргах, үйлчлүүлэгчдэд зовиур үүсгэхгүй байх зорилгоор Яаралтай тусламжийн үед авч хэрэглэхэд хялбар, эрж хайхгүй, гарын доорх

материалаар хийгдсэн. Үйлчлүүлэгчид стандартын дагуу хүйтэн жин тавих иж бүрдэлийг тасаг нэгжүүд өргөн хэрэглэж байна.



Тархины эмгэгшилийг илрүүлэх тоон шинжилгээний тестын арга”: Тархины эмгэгшилийг илрүүлэх тоон тестийн аргыг 1 жил 2 сарын дараа тархины цусан хангамж сайжруулах эм уулгаж үр дүнг тооцоход тестийг гүйцэтгэх хугацаа богиноссон байна. Өвчтөний анхааралыг төвлөрүүлэн суулгаж зааварчилгааг өгч секундомерээр 1 минутын турш гүйцэтгэнэ. 21 хүнд оношлогоог хийж үр дүнг тооцсон. Үүнд 12 хүн эргэж хамрагдснаас 8 хүнд нь эерэг үр дүн буюу гүйцэтгэх хугацаа богиноссон байсан. Оношлогоонд хамрагдсан 21 хүнээс:

- Тархины эмгэгшилгүй -3
- Далд тархины эмгэгшил-8
- Тархины эмгэгшил -1 st -5. 2 st -4. -3 st -1 байлаа.



Түргэн тусламжийн үйлчилгээний шинэчлэл: ЭМТ-ийн яаралтай тусламжийн үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлын хүрээнд 2019 онд НЭМГ-ын хөрөнгө оруулалт /30 сая.төг/-аар агуулахын журмаар ашиглаж байсан 246 м2 талбайд засвар тохижилтыг бүрэн хийж стандартын шаардлага хангасан байранд бие даан, автограшийн хамтаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Үүний хүрээнд түргэн тусламж 103-ийн их эмч нарыг 4 байсныг 8 болгон, жолооч нарыг парамедикийн давтан сургалтанд хамруулсан.Төдийгүй Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Түргэн



тусламж-103-ийн зориулалтын иж бүрэн 1 автомашин, Нийслэлийн түргэн тусламжийн төвөөс балансаас балансад шилжүүлэн 1 автомашин нийт **түргэн тусламжийн 2 автомашинаар парк шинэчлэл** хийлээ.

Цаашид түргэн тусламжийн автомашинуудыг GPS, богино долгионы станцаар хангах, түргэн тусламжийн дуудлага хүлээн авах болон дуудлагын үзлэгийн эмч нарыг утасны яриа бичигч төхөөрөмж, энгэрийн камераар хангах, эмч мэргэжилтнүүдийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх зэргийг төлөвлөн ажиллаж байна.



Б. Оношлогоо, шинжилгээний чиглэлээр

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Еврофарм ХХК-ны нийлүүлсэн 267 сая. төг-ний өртөг бүхий **Дижитал рентген аппараттай болж** 2019.01.01-ээс эхлэн оношлогоонд тогтмол ашиглаж нийт 10577 хүнд үйлчилгээ үзүүлээд байна. Уг рентген аппараттай болсноор:

- Хамрын хугарал
- Нурууны хугарал болон бусад өөрчлөлтүүд
- Гавлын суурь ясны хугарал
- Жижиг шивнүүр ясны хугарал /хөл сарвуу г.м/
- Уушигны хавдар
- 1 нас хүртэл оношлогдоогүй явсан хүүхдийн өрцны ивэрхий зэрэг ховор, онцлог тохиолдлуудыг оношлож байна.



Уушигны сүрьеэ болон булаа, өрцны ивэрхий, хавдарын сэжигтэй тохиолдол нийт 25, Бүх төрлийн рентген оношлогооны зургийн чанар эрс сайжирсан.

Тодосгогч бодистой рентген шинжилгээг эмэгтэйчүүдэд үрийн хоолойн битүүрэл шалгах 5 хүнд, хүүхдэд ивэрхий болон гэдэсний түгжрэл шалгах 2, улаан хоолойн нарийсал ба хавдарын ялган оношлогоо хийх зорилгоор 1 хүнд нийт 8 хүнд хийгээд байна.


Шулуун бүдүүн гэдэсний оношлогооны апараттай болсон. УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргилын дэмжлэгээр Арабын нэгдсэн Эмират улсын элчин сайдын тусламжаар шулуун бүдүүн гэдэсний оношлогооны 21 инчийн 100170,95 мян.төг-ний өртөг бүхий уян дуран, 130600,0 мян.төг-ний 3D өнгөт ЭХО аппарат, 3750,0 мян.төг-ний өртөг бүхий 3750,0 мян.төг-ний үтрээний поробтой болж үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.



Ходоод шулуун гэдэсний оношлогооны эмч, сувилагч нарыг УНТЭ-т мэргэжил олгох сургалтанд 2018.03.01-ээс эхлэн

3-6 сарын хугацаагаар мэргэжил олгох сургалтанд хамруулан бэлтгэсний үр дүнд 2019 онд оношлогоог тасралтгүй жигд үзүүлж байна.

Мөн программ хангамжийг 1,5 сая.төг-өөр суурилуулан, уг оношлогоог нэвтрүүлэхэд шаардлагатай оношлогооны аппаратын ариутгалын уусмал, тусгай зориулалтын угаалгын машин зэргийг хангах ажлыг зохион байгуулсан.



Ходоодны дурангийн оношлогоог 777 хүнд хийж, ходоодны шарх 57, ходоодны ургацаг 15, улаан хоолойн дивертикул 2, улаан хоолойн мөөгөнцөр 3, ангиодисплази 2 илэрсэн. Ходоодны шархтай хүмүүсийг эмнэлэгт хэвтү үлэн эмчлэх болон амбулаториор эмчилгээ хийж, хяналтанд хянагдаж байна. Улаан хоолойн судасны өргөсөл 46 хүнд оношилж, дээд шатлалын эмнэлэгт илгээж судас боох эмчилгээнд хамруулсан. “Элэг бүтэн “ хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор 277 хүнд С вирус, 21 хүнд В вирус, 62 хүнд ВД вирус илэрсэн ба вирус тоолох шинжилгээнд хамруулсан. Ходоодны хавдарын эрсдэлт хүчин зүйл болох Н.рylogi-ийг илрүүлэх амьсгал болон өтгөний шинжилгээнд 76 хүнийг хамруулсан. С вирусын эсрэг эмчилгээнд 68 хүн хамрагдаж, 66 хүний эмчилгээ хийгээд дууссан ба одоо 2 хүнд эмчилгээ хийгдэж байна. В вирусын эсрэг эмчилгээнд 56 хамрагдсан.

УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргилын дэмжлэгээр Арабын нэгдсэн Эмират улсын элчин сайдын тусламжаар 2018 оны 2-р сарын 28 нд **4D өнгөт ЭХО аппарат** хүлээн авсан. **Уг ЭХО-ны оношлогооны ач холбогдол, давуу тал нь:**

- Зургийн нягтрал сайтай учир нойр булчирхай болон элэгний хавдарыг эрт үед нь /0,1мм байх/ оношлох боломжтой
- Өөртөө зураг хадгалах, илгээх системтэй учир оношлогооны зургийг эмч нар луу цахимаар илгээх боломжтой.

2018 онд 5649 хүнд оношлогоо хийж хавдрын 57 тохиолдлыг илрүүлэн ажилласан бол 2019 оны 03 сарын 27-нд Япон улсын “HITACHI” фирмийн “HI VISION Avius” загварын өндөр хүчин чадал бүхий хэт авиан /ЭХО/ оношлогооны аппаратыг ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар СІТ ХХК нийлүүлснийг хүлээн авч ашиглаглалтанд орууласнаас хойш нийт 10667 хүнд оношлогоо хийсэн. Цэсний хүүдийн ургацаг, чулуу 25, элэгний хавдрын сэжигтэй тохиолдол 32, бөөрний үүсгүүр 5, нойр булчирхайн үүсгүүр 11, бусад 11 нийт 74 онцгой тохиолдолыг эрт илрүүлэн оношлосон.



Монгол-Швейцарийн хамтарсан хүүхдийн төсөл (SMOPP)-өөс “Нярайн түнхний дутуу хөгжлийн хэт авиан скрининг” оношилгоог 2015 оноос хойш хийж байгаа бөгөөд 2019 онд нийт 564 нярайд хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлж чаджээ. Оношлогоонд хамрагдсан 564 нярайн 508 /90%/ нь А, 49 /8,7%/ нь В, 6 /1,1%/ нь С, 1 /0,18%/ нь D үнэлгээтэй байсныг хяналтанд авч, эмчилгээнд хамруулсан.




Зайн оношлогоо нэвтэрлээ: НҮБ –ийн хүн амын сангийн “Эх нярайн зайн оношилгооны төсөл”-ийн хүрээнд төрөх тасагт зайн оношилгооны өрөөг 2017 оны 7сард нээснээр хүнд өвчтөнд цаг алдалгүй лавлагаа шатлалын эмнэлгээс оношилгоо эмчилгээнд зөвлөгөө авах боломж бүрдэн ЭХЭМҮТ-тэй шууд харилцаж байна.



Оношлогоо, шинжилгээний чанарыг сайжруулах зорилгоор сүүлийн үеийн оношлогоо шинжилгээний гематологийн болон **Insight U500 шээсний стрип уншигч** аппаратыг түрээсийн гэрээгээр Баянгол мед ХХК-аас шинээр авч суурилуулан ажиллуулж байна. Уг шинжилгээний аппаратууд нь:

- ✓ E-health программд хариуг илгээж, эмч нарт дамжуулах боломжтой
- ✓ Цусны эсийн бүтцийг графикаар гаргах
- ✓ Нугасны ус тоолох
- ✓ Цусны залуу эс тоолох
- ✓ Өндөгний цусыг шингэлж унших зэрэг давуу талуудтай.



Тайлант хугацаанд гематологийн шинжилгээ нийт 19505 хүнд, шээсний шинжилгээ 19484, биохимийн шинжилгээ 18033 хүнд 107499 үзүүлэлт тус тус хийж үйлчилсэн байна.

Амьсгалаар хеликобактерийг оношлох шинжилгээний аргыг нэвтрүүлээ. Уг арга нь орчин үеийн дэвшилтэт технологи бөгөөд нийт 120 үйлчлүүлэгч хамрагдсан ба оношлогооны чадавхи өндөр тул эмчилгээний үр дүнг хянахад ач холбогдолтой байна.



Нян судлалын лаборатори vitek® 2 compact нь 100 гаруй бактери, мөөгөнцрийн ялган дүйж, 50 гаруй антибиотик мэдрэг чанарыг тодорхойлдог боллоо. Монгол улсын засгийн газар, Эрүүл мэндийн яам, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан гэрээний дагуу “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” төслийн хүрээнд хийгдсэн “Төвлөрсөн ариутгал, Нян судлалын лаборатори”-ийн их засварын ажил, тоног төхөөрөмжийг хийж гүйцэтгэсэн Энэхүү төсөл хэрэгжсэнээр тус эмнэлгийн нян судлалын лабораторийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжрахаас гадна эмнэлгийн тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт хяналт сайжирч, эрүүл ахуй, халдварын сэргийлэлтийн үйл ажиллагаа сайжирч орчин үеийн дэвшилтэт, шинэ технологи бүхий тоног төхөөрөмжүүдээр хангагдсан, эмч мэргэжилтэнд хардварын сэргийлэлт, хяналтын талаархи шинэ мэдлэг олгох, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, улмаар хуучин мөрдөж хэвшсэн уламжлалт арга барилыг өөрчилөн шинэчлэх, эмнэлгийн тусламж үзүүлэх үйл ажиллагааныхаа олон сургалтуудыг зохион байгуулснаар салбарын эмч мэргэжилтнүүдэд томоохон оюуны хөрөнгө оруулалт хийсэн ач холбогдолтой.



Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 оны 3 сард 29.8 сая төгрөгийн өртөг бүхий **плазмын автоклаваар** хангагдсны үр дүнд:

- Эмэгтэйчүүдийн зөвөлгөө өгөх кабинетийн гуурс
- Дурангийн мэс заслын туслах материал, хэрэгсэл

- Ходоодны дурангийн хэрэгсэл
- Хүлээн авах, хүүхэд, эрчимтийн тасагт хэрэглэгдэж буй амбуны болон бусад хуванцар хошуу, гуурс
- Чих хамар хоолойн кабинетийн туслах материал зэрэг 17 нэр төрлийн 537 ширхэг хуванцар материалуудыг ариутгасан байна.

Ариутгалын үйл ажиллагаанд эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер болон халдвар судлагч эмч тогтмол хяналт тавин, химийн хяналтын аргаар хянаж, сард 1 удаа “Bowie Disk” тест ашиглан хяналт тавин ажиллаж байна.

Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндэд анхаарч хүүхэд залуучуудын дунд элбэг тохиолддог гүйлсэн булчирхайн архаг үрэвслийг төгс эмчлэх зорилгоор гүйлсэн булчирхай авах мэс заслыг 8 хүнд хагалгааг орон нутагтаа хийсэн. УНТЭ-ийн ЧХХКСудлалд 48 хүнийг илгээж, гүйлсэн булчирхай авах хагалгаа 13, чихний хэнгэрэг нөхөх хагалгаанд 12, залгиурын буглаа 5, хамрын таславч мөгөөрсийг тэгшлэх хагалгаанд 18 хүнийг тус тус хамруулсан. Дүлийрэлтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд “ЭММЖ” ХХК-ний эмнэлгийн эмч нартай хамтран ажиллаж АССР шинжилгээнд 70 хүн, сонсголын аппарат 12 хүнд олгосон.

Эрүүл мэндийн статистик үзүүлэлт 2019 оны эхний 11 сарын байдлаар:

2019 оны эхний 11 сарын байдлаар нийт үзлэг 213617 болж 77.8 хувь нь дүүргийн эрүүл мэндийн төвд, 22.2 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хийгдсэн байна. Үзлэгийн бүтцийн хувьд урьдчилан сэргийлэх үзлэг 45.25 хувь, өвчний учир амбулаторийн үзлэг 43.5 хувь, идэвхтэй хяналтын үзлэг 5.0 хувь, гэрийн идэвхтэй хяналтын үзлэг 6 хувь, гэрийн дуудлага 0.3 хувийг эзэлж байна.

Стационарын тасагт 7495 өвчтөн хэвтэн эмчлүүлж нийт 52289 ор хоног ашигласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эмчлүүлсэн өвчтөн -266-аар буурч, ор хоног 756-р буурсан байна. Дундаж ор хоног 6.99 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.14-р өссөн, орны эргэлт 34.97 болж -1,24-аар буурсан байна. Орны фонд ашиглалт 244.34 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3,53-аар буурсан байна.

№	Үзүүлэлтүүд	Нэгж	2018.11	2019.11	Зөрүү
1	Хэвтсэн өвчтөн	бодит тоо	7746	7495	-251
2	Гарсан өвчтөн	бодит тоо	7729	7448	-281
3	Эмчлүүлсэн өвчтөн	бодит тоо	7750	7484	-266
4	Ашигласан ор хоног	бодит тоо	53045	52289	-756
5	Орны фонд ашиглалт	бодит тоо	247.87	244.34	-3.53
6	Орны фонд ашиглалтын хувь	бодит тоо	81.94	80.77	-1.17
7	Дундаж ор хоног	бодит тоо	6.84	6.99	0.14
8	Орны эргэлт	бодит тоо	36.21	34.97	-1.24

2019 оны эхний 11 сарын байдлаар 570 эх төрсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65 төрлөг буюу 10.2 хувиар буурсан байна. Нийт төрөлтийн 28.1 хувь нь кесаров хагалгаагаар төрсөн нь өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өссөн байна. Амьгүй төрөлтийн 6 тохиолдол бүртгэгдэж 1000 нийт төрлөгт 11.0 болсон нь өмнөх оны мөн үеэс 7.7 промиллоор өссөн мөн гэрийн төрөлтийн 2 тохиолдол бүртгэгдэж нийт төрөлтийн 0.3 хувийг эзэлж байна.

Жирэмсний хяналтанд шинээр авсан эмэгтэйчүүдийн тоо 703, үүнээс эхний 3 сартайд хяналтанд орсон 610 (86.77 хувь) байна. Жирэмсний хяналтанд авсан эмэгтэйчүүдийн 9.2 хувь нь үр хөндүүлсэн, 6.7 хувь үр зулбасан байна.

Нас баралтын нийт 119 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 тохиолдол буюу 0.8 хувиар буурсан байна. Эмнэлгийн нас баралтын 24 тохиолдол бүртгэгдсэн нь нийт нас баралтын 20.1 хувийг эзэлж байна. Үүнээс хоног болоогүй нас баралт 11 тохиолдол буюу эмнэлгийн нас баралтын 45.8 хувийг эзэлж өмнөх оны мөн үеэс 37.5 хувиар өссөн байна. Нийт нас баралтын 30 тохиолдол буюу 25.2 хувь нь хорт хавдрын, 11 тохиолдол буюу 9.2 хувь нь гадны шалтгаант нас баралт байна. Хорт хавдрын нас баралт өмнөх оны мөн үеэс 13 тохиолдол буюу 10.6 хувиар буурсан байна.

2019 оны эхний 11 сарын байдлаар нялхсын эндэгдэл өмнөх оны мөн түвшинд /НЭМГ-ын эргэн мэдээлэхээс/, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

№	Үзүүлэлтүүд	нэгж	2018.11	2019.11	Зөрүү
1	Нийт нас баралт	бодит тоо	119	119	-1
2	Эмнэлгийн нас баралт	бодит тоо	24	24	0
3	Хоног болоогүй нас баралт	бодит тоо	2	11	9
		хувь	8.3%	45.8%	37.5%
4	Нялхсын эндэгдэл	бодит тоо	7	6	-1
		1000 амьд төрөлтөд	11.5	11.2	-0.3
5	Перинаталь эндэгдэл	Бодит тоо	4	9	5

Нас баралтын тэргүүлэх 3 шалтгаан:

№	Үзүүлэлт	Нэгж	2018.11	2019.11
1	Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	Бодит	119/40	119/51
		Хувь	33.6	42.8
2	Хавдар	НБ/Бодит тоо	119/44	120/40
		Хувь	36.9	33.6
3	Осол гэмтэл, гадны шалтгаан	Бодит тоо	119/16	119/10
		Хувь	13.4	8.4

Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувьд:

- артерийн гипертензи өвчний эрт илрүүлэгт 7920 хүн хамрагдахаас 5450 хүн буюу 68.8%
- чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт 7920 хүн хамрагдахаас 5537 хүн буюу 69.9%
- умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт 1792 хүн хамрагдахаас 1046 хүн буюу 58.4%
- хөхний хавдрын эрт илрүүлэгт 7833 хүн хамрагдахаас 4338 хүн буюу 55.4%
- Элэгний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 758 хүн хамрагдахаас 552 хүн буюу 72.8 хувь нь тус тус хамрагдаад байна.

Халдварт өвчний нийт 340 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 158 тохиолдол буюу 31.7 хувиар буурч 10000 хүн амд 116.64 болсон байна. Үүн дотроо бэлгийн замын халдварт өвчин 163 тохиолдол бүртгэгдэж

өмнөх оноос 42 тохиолдол буюу 10000 хүн амд 15.07 тохиолдлоор буурсан бол цочмог халдварт өвчний 156 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 114 тохиолдол буюу 10000 хүн амд 39.97-р буурсан байна. Мөн шинэ сүрьеэгийн 21 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 тохиолдол буюу 8.6 хувиар буурсан байна.

№	Үзүүлэлтүүд	нэгж	2018.11	2019.11	Зөрүү
1	Бэлгийн замын халдварт өвчин	Бодит тоо	205	163	-42
		10000 хүн амд	70.98	55.92	-15.07
2	Цочмог халдварт өвчин	Бодит тоо	270	156	-114
		10000 хүн амд	93.49	53.52	-39.97
3	Сүрьеэ өвчин	Бодит тоо	23	21	-2
		10000 хүн амд	7.96	7.20	-0.76
4	Нийт халдварт өвчин	Бодит тоо	498	340	-158
		10000 хүн амд	172.44	116.64	-55.80

Статистик үзүүлэлтийг сайжруулах чиглэлээр: Байгууллагын хэмжээнд 51 төрлийн үндсэн үзүүлэлтийг сар, улирлаар дүгнэж ажилладаг бөгөөд энэ жилийн хувьд хоног болоогүй нас баралтыг бууруулах, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь нэмэгдүүлэх, мэс заслын хүндрэл гаргахгүй ажиллах, эрт илрүүлгийн үзлэгийн хувийг нэмэгдүүлэх, зэрэг үзүүлэлтүүд дээр илүү анхаарч ажилласан. Мөн мэдээ тайлангийн үнэн бодит байдлыг хангах, иргэд болон эмч мэргэжилтнүүдийг эргэн мэдээллээр тогтмол ханган ажиллах тал дээр анхаарч ажилласан.

- Байгууллагын хэмжээнд “Бүртгэл мэдээллийг сайжруулах” 14 хоногийн аяныг тасаг нэгжүүдийн дунд зохион байгуулж дүгнэн, шалгарсан тасгуудыг урамшуулсан.
- НЭМГ-аас 2019.6.3-ны өдөр баталсан удирдамжийн дагуу хийсэн хяналт үнэлгээнд <http://www.bnemn.ub.gov.mn> сайтад тавигдсан статистик мэдээллийн цэс шалгагдаж хангалттай ажилласан гэж үнэлэгдсэн.
- НЭМГ-аас зарласан 3 сарын “Статистик бүртгэл мэдээллий аян”-ны төлөвлөгөөнд 11 ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн. Биелэлт – 91%
Аяны хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудаас:
- Үндсэн үзүүлэлтийг сайжруулахын тулд НЭМГ-ын чанарын ахлах мэргэжилтэнг урьж “Гэрийн нас баралтын оношийн асуудал ба түүний шийдэл” сэдэвт сургалтыг аяны хүрээнд зохион байгуулсан.
- Багануур дүүргийн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт – 2018 он номыг эмхэтгэн хэвлүүлж, байгууллагын удирдлага, эмч мэргэжилтнүүдийг мэдээллээр хангаж ажилласан.
- Өвчтөний түүхийг хадгалдаг архивын байранд шинээр тавиурууд суурилуулан хадгаламжийн нэгжийг цэгцэлсэн.
- Мөн эмч болон сувилагч нарын дунд амь тэнссэн үеийн авах арга хэмжээний сургалтыг УБ хотоос мэргэжлийн багш нарыг урьж 2 удаагийн сургалт зохион байгуулж, сургалтын үр дүнг баталгаажуулах зорилгоор эмч сувилагч нарын дунд ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулсан. Мөн түргэн тусламж 103-ийн жолооч, туслах сувилагч нарын дунд парамедикийн сургалтыг хийсэн.

3.4 Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор сууршилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв нь 230 ор, 17 тасаг нэгжтэйгээр дүүргийн болон Төв, Хэнтий аймгийн ойролцоох 8 сумдын хүн амд нэгдсэн эмнэлгийн бүтэц, орон тооны стандарт MNS5095:2017-ын дагуу тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Хүний нөөцийн хувьд нийт 314 ажилтантай. Үүнд:

- Их эмч 69
- Эм зүйч 2
- Халдвар судлагч их эмч 1
- Нийгмийн эрүүл мэндийн ажилтан - 2
- Биоанагаах судлаач 2
- Сувилагч, эмнэлгийн тусгай дунд мэргэжилтэн 140 /сувилагч 102, тусгай мэргэжилтэн 38/
- Туслах сувилагч 7
- Бусад дээд мэргэжилтэн 14
- Үйлчлэгч 35, бусад туслах үйлчилгээний ажилтан 34 ажиллаж байна.

Одоогийн байдлаар:

- 10000 хүн амд ноогдох их эмчийн тоо 35
- 10000 хүн амд ноогдох сувилагч, эмнэлгийн тусгай дунд мэргэжилтний тоо 48
- Нэг эмчид ноогдох сувилагчийн тоо 1.4 байна.

Эмч, Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэргийн хувьд:

- Тэргүүлэх зэрэгтэй эмч 5
- Ахлах зэрэгтэй эмч 13
- Тэргүүлэх зэрэгтэй сувилагч дунд мэргэжилтэн 11
- Ахлах зэрэгтэй дунд мэргэжилтэн 57 болж эмч нарын 27%, дунд мэргэжилтнүүдийн 48% нь мэргэжлийн зэрэг хамгаалж мэдлэг мэргэжил ур чадвараа дээшлүүлсэн.

Боловсролын зэрэг цолны хувьд:

- Клиникийн профессор цолтой эмч 8
- Магистр эмч 17, сувилагч 2, нийт 19 эмнэлгийн мэргэжилтэн
- Бакалавр зэрэгтэй сувилагч -26 ажиллаж байна.

Эмч нарын 89%, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн 52.4% нарийн мэргэжил эзэмшсэн. Нарийн мэргэжил шаардагдах ажил, албан тушаалын хангалт 90% байна.

Тайлант хугацаанд аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүтэц орон тооны стандарт MNS5095:2017-ын дагуу ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор

- Нөхөн үржихүйн эрүүл мэнд хариуцсан НЭМ-ийн зохицуулагч
- Тархины цахилгаан бичлэг хийж эхэлсэн
- Хүлээн авахын өдрийн сувилагч
- Гэмтлийн мэс заслыг дүүргийн болон тойргийн сумдын иргэдэд үзүүлж эхэлсэн

- Ходоодны дурангын эмч, сувилагч
- Хөнгөвчлөх, хими эмчилгээний өдрийн сувилагч
- Амбулаторийн хөтөч сувилагч 5
- Түргэн тусламж 103 тасгийн бүтэц орон тоог 8 их эмчтэй болгосоноор орон болон хөрвөн ажиллах нөхцөл бололцоогоор хангаж өгсөн.

Мэргэшүүлэх болон чадваржуулах сургалтанд хамруулж, мэдлэг мэргэжил, боловсролыг дээшлүүлж буй байдал:

Тайлант хугацаанд байгууллагад хэрэгцээ шаардлагатай, дутагдалтай байсан чиглэлээр эмч, сувилагч нарын сар бүрийн үндсэн цалинг олгон сургалтаа төгсөөд тус эрүүл мэндийн төвд 5-10 жил тогтвор суурьшилтай ажиллах хатуу гэрээ байгуулсан сургалтанд хамруулаад байна. Үүнд:

- Эмэгтэйчүүдийн мэс засал судлалын эмч - 1
- Хүүхдийн мэс засал судлалын эмч - 1
- Гемодиализийн сувилахуй – 1
- Био анагаахын мэргэжил дээшлүүлэх сургалт - 2

Мөн үндсэн мэргэжил олгох сургалтанд:

- Гэмтэл согог засал судлал-1
- Мэдээгүйжүүлэг судлал -1
- Нүд судлал -2
- Хүүхэд судлал- 3
- Дүрс оношлогоо судлал -1
- Сэтгэц судлал-1
- Чих хамар хоолой судлал -2
- Дотор судлал-3
- Хавдар судлал-1
- Эх барих эмэгтэйчүүд судлал -1
- Яаралтай түргэн тусламж судлал-1
- Сүрьеэ судлал-1 зэрэг чиглэлүүдээр нийт 18 их эмчийг сургалтанд хамруулсан нь Эрүүл мэндийн төвийн эмчилгээ үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэхэд чухал нөлөө бүхий ажил боллоо.

Тайлант хугацаанд байгууллагад хэрэгцээ шаардлагатай, дутагдалтай байсан.

- Хүүхдийн мэс засал судлалын эмч -1
- Хүүхдийн мэдээгүйжүүлгийн их эмч -1
- Эрчимт эмчилгээний их эмч -1
- Гэмтлийн их эмч-1
- Ерөнхий мэдээгүйжүүлгийн их эмч-1
- Гемодиализийн техникч – 1
- Лабораторын эмч -2 чиглэлээр эмч, сувилагч нар сургалтаа төгсөөд тус эрүүл мэндийн төвд 5-10 жил тогтвор суурьшилтай ажиллах гэрээтэйгээр ажиллаж эхлээд байна.

Тайлант онд Клиникийн профессор эмч- 4, мэргэжлийн “Ахлах” зэрэг 4 их эмч, сувилахуйн мэргэжлийн “Ахлах” зэрэг 3 сувилагч, “Тэргүүлэх” зэрэг 1

сувилагч, 2,5 жилийн бакалаврын сургалтанд 2 эх баригч бага эмч суралцаж бакалаврын боловсрол эзэмшсэн нь өмнөх оны мөн үеэс 50 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Богино хугацааны болон багц цагийн сургалт:

Харьяа дээд байгууллага, мэргэжлийн нийгэмлэгүүд, лавлагаа шатлалын эмнэлгүүдээс зохион байгуулсан богино хугацааны сургалтанд давхардсан тоогоор 154 эмч, 101 сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан.

Нийт ЭМТ-ийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд багц цагийн сургалтанд давхардсан тоогоор 272 их эмч, 442 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдаж, багц бүрдүүлэлтийн хувь 98%-тай байна.

Эрүүл мэндийн төвийн дарга Д.Шинэбаяр 2019-03-01 нээс ЭМШУИС-д “Эрүүл мэндийн удирдлага” сэдэвт 6 сарын хугацаатай мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж төгссөн.

2019-04-05 нд ЭМЯ-наас зохион байгуулсан “Ёс зүй, зөв хандлага” сэдэвт сургалтанд байгууллагын удирдлагын зөвлөлийн гишүүд /ерөнхий нягтлан бодогч Б.Наранцэцэг, эдийн засагч, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн Д.Мөнгөнцацрал, хүний нөөцийн менежер Б.Оюунбаатар/ хамрагдсан.

“Сэтгэлийн өнгө” сэтгэл зүйн төвийн сэтгэл зүйч, доктор Г.Наранбаатар, Б.Одгэрэл нарыг урьж ирүүлэн “Эерэг хандлага” сэдэвт сургалтыг 6 сарын 06-ны өдөр дүүргийн Эрүүл мэндийн салбарын ажилтнуудад байгууллагын удирдлага, эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, туслах ажилчдад зохион байгууллаа.

“Амь тэнссэн үеийн үнэлгээ болон тусламж” сэдэвт гардан үйлдлийн ур чадварын уралдааныг ОУ-ын эмч нарын өдрийг тохиолдуулан дүүргийн нийт эмч нарын дунд, ОУ-ын сувилагчдын өдрийг тохиолдуулан Багануур, Налайх, Багахангай дүүргийн нийт сувилагч, мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан.



Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дундах ур чадварын тэмцээнийг Багануур дүүргийн Засаг даргын дэмжлэгтэйгээр Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан бөгөөд дарга хэмжээгд НЭМГ-н Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын ахлах мэргэжилтэн Э.Энхжаргал, Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Ц.Сонгиносүрэн, Бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн С.Тунгалаг, Сүхбаатар, Хан-Уул, Энэрэл

эмнэлэг, Түргэн тусламжийн төв, Хонхор тосгоны чанарын болон сувилахуйн албаны дарга нар, холбогдох байгууллагуудын удирдах албан тушаалтангууд урилгаар оролцсон. Уралдаанд нийт 16 баг оролцож 6 төрлөөр өрсөлдсөн бөгөөд 1-р байрт Багануур ЭМТ-ийн нярайн тасгийн "Нялхас" баг, 2-р байрт Налайх ЭМТ-ийн "Эрүүл амьдрал" баг, 3-р байрт Багануур ЭМТ-ийн ЭЭХА тасгийн "Манлайлагч" баг, Тусгай байрт Багануур сувилал ХХК-ийн "Энх цагийн сувилагчид" баг, Багануур ӨЭМТ-ийн "Зүрх зогсохгүй" баг амжилттай оролцож өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.



Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор лавлагаа шатлалын ЭХЭМҮТ, АШУУИС-ын мэс заслын тэнхим, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн мэс заслын эмч нартай хамтран:

- Нярайн мэс засал -2
- Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал-1
- Хэвлийн дурангийн мэс засал-14 өвчтөнд

• Өвдөгний үе солих мэс засал-1 өвчтөнд хамтран хийсэн нь мэс заслын нэр төрлийг нэмэгдүүлж, тусламж үйлчилгээг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байлаа.

Эмч нарын Эмнэл зүйн хэлэлцүүлэг /Конференци/ зонхилон тохиолддог болон ховор тохиолддог эмгэгүүдээр 5 удаагийн хэлэлцүүлгийг ЭХЭМҮТ, УГТЭ, АШУУИС, ХӨСҮТ, УНТЭ-ийн эмч нартай хамтран давхардсан тоогоор 150 эмчид онолын болон дадлага ажлын сургалтыг зохион байгуулсан. Үүнд:

- Хүүхдийн ясны идээд үрэвсэл
- Сүрьеэгийн өвчлөл
- Уушигны эмгэг /ховор тохиолдол/
- Хоол боловсруулах замын эмгэг /ховор тохиолдол/ гэх мэт




Эрүүл мэндийн чанарын холбооноос “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал” сэдэвт 5 өдрийн 40 цагийн сургалтанд Чанарын албаны дарга Ц.Балжидмаа хамрагдсан. Үүний хүрээнд цаашид 3-р улиралд Арьсны өвчин судлалын төвийн “ISO стандартыг хэрэгжүүлсэн туршлага”, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Брендбүк нэвтрүүлсэн тухай” туршлагаудыг судалж ажилдаа нэвтрүүлж ажиллахаар төлөвлөж байна.

Үйлчлэгч нарын ур чадварын уралдаан: Үйлчлэгч нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, холбогдох тушаал зааврын биелэлтийг сайжируулан, эмнэлгийн тусламж үйлчилгээний халдвар хамгаалал, ёс зүй, харьцаа хандлагын талаархи мэдлэгийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, багаар ажиллах чадварыг сайжруулах, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор “Ур чадварын уралдаан”-ыг зохион байгууллаа.



Гадаад сургалт, хамтын ажиллагаа, туршлага судалсан байдал:

ЭМТөвийн дарга Д.Шинэбаяр НЭМГ-ын удирдлагууд болон харъяа ЭМТ, нэгдсэн эмнэлгийн удирдлагууд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх албан айлчлал хийх бүрэлдэхүүнд багтан 2019 оын 05 сарын 13-17-ны өдрүүдэд Хөх хоттой эрүүл мэндийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, туршлага солилцох, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах ажлыг үр дүнтэй зохион байгуулах чиглэл туршлага судлан ажилласан.






Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Наркологийн төв ОХУ-ын Улан-үдэ хотын Дорнод сибирийн их сургуультай танилцан Сэтгэц, наркологийн орчин үеийн тусламж үйлчилгээний талаарх 3 өдрийн сургалтанд Сэтгэц, Наркологийн их эмч С.Байгалмаа хамрагдсан.



Монголын Радиологийн нийгэмлэгээс зохион байгуулсан ОХУ-ын Улан-үдэ хотод Дүрс оношилгоо, хэт авиан оношилгооны эмч нарын ОУ-ын эрдэм шинжилгээний баг хуралд Дүрс оношилгооны их эмч Г.Одонтуул, Рентген техникч А.Батцэцэг нар 2019 оны 05 сарын 16-17-ний өдрүүдэд амжилттай оролцсон.



БНСУ-ын Инчён хотын Инха эмнэлэг, Гангвонг хотын Асан эмнэлэгүүдийн үйл ажиллагаатай Эрүүл мэндийн төвийн Удирдлагын зөвлөлийн гишүүд 5 хоногийн хугацаатай танилцах аялал хийж, хамтран ажиллах гэрээ байгуулсан.



Халдвартын тасгийн эрхлэгч их эмч Н.Ариунболд БНХАУ-ын Цун-чин хотод зохион байгуулагдсан "Сүрьеэ өвчнийг устгая" сэдэвт олон улсын хуралд 3 хоног, БНСУ-ын Инчён хотын "Гэгээн Мариягийн нэрэмжит эмнэлэгт" сэргээн засах эмчилгээний чиглэлээр 7 хоногийн сургалтанд, Мэдрэлийн их эмч А.Мөнхжаргал Бүгд найрамдах Солонгос улсын Сөүл хотод болсон Эпилепсийн олон улсын хуралд 5 хоног, Эм зүйч О.Отгончимэг БНСУ-ын Сөүл хотод "17 дах фарм экспо"-д оролцон "Мартин" эмнэлгийн эм зүйн тасгийн үйл ажиллагаатай танилцах 5 хоногийн сургалт аялалд тус тус хамрагдсан.



Зүрх судасны их эмч Л.Чимэдлхам БНХАУ-н Бээжин хотод "Нэг зам нэг бүс" хөтөлбөрийн хүрээнд "Монголын зүрх судасны өвчний урьдчилан сэргийлэлт болон эмчлэх технологи" сэдэвт сургалтанд 21 хоног

Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн С.Оюунцэцэг, Эх барих эмэгтэйчүүдийн их эмч Ж.Сайнхүү нар БНСУ-ын Сөүл хотын "Хапвит" хүүхдийн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцсан.

2019 онд "Энэрэл" АУДС-тай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр 2 ээлжээр 40 гаруй оюутнуудад эх барих, сувилахуйн дадлагыг клиникийн 5 тасаг, нэгж дээр хийлгэж, арга зүйн зөвлөгөө зааварчилгааг өгөн ажиллаж байна.



Судалгаа, шинжилгээ:

"Эх хүүхэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сувилагчийн оролцоо" эрдэм шинжилгээний хурлыг 2019.04.26 өдөр зохион байгуулсан ба сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн хамтран хийсэн 11 илтгэлээс байгууллагын эрдмийн зөвлөл шалгаруулалт хийж 5 илтгэлийг хэлэлцүүлсэн Илтгэлийн уралдааныг АШУҮИС-ийн НЭМСургуулийн багш Гантуяа, Ангармөрөн ЭМТ-ийн эрдмийн зөвлөлийн дарга дотоод шүүрлийн кабинетын их эмч Анагаах ухааны магистр С.Гэрэлцэцэг нар шүүн явуулсан. Тэргүүн байранд рентген техникч А.Батцэцэгийн **"Багануур дүүргийн игэдийн цацаргийн аюулгүй байдлын талаархи мэдлэг хандлагыг үнэлсэн нь"**, Эх баригч бага эмч Ц.Алигэрмаагийн **"Сүүлийн 5 жилд багануур дүүрэгт бүртгэгдсэн өсөлтгүй жирэмслэлт болон зулбалтын тохиолдлыг үнэлсэн байдал"** илтгэлүүд

шалгарч НЭМГ-аас зохион байгуулж буй хоёр дугаар шатны уралдаанд амаар болон ханын хэлбэрээр хэлцэгдэн сувилагч А.Батцэцэгийн судалгааны ажил 3-р байрт шалгарсан.



Мөн зүүн гурван дүүргийн сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд олон улсын сувилагчдын өдөр угтан зохион байгуулах ажлыг хамтран хийхээр төлөвлөсөний дагуу Налайх дүүрэгт 2019.04.30 өдөр “Эрдэм-2019” эрдэм шинжилгээний хурал болж 18 илтгэл хэлцэгдэж сувилагч Б.Алтансүвдэн “ЭМТ-ийн ажилчдын эрсдэлд өртсөн байдлыг судлах нь” судалгааны ажил 2-р байрт шалгарсан



2019 онд ОУ-ын эмч нарын баяраар их эмч Н.Очирмаа, С.Байгалмаа нарын “Зүрхний дутагдлын үеийн амьдралын чанар” сэдвээр ОПБХ-д илтгэл тавьж дүүрэгт “Нэгдүгээр байр”, Зүрх судасны үндэсний конференцид постер илтгэлээр шалгарсан.



2019 оны 4 сард АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хуралд их эмч С.Байгалмаа нь “Багануур дүүргийн ЭМТ-ийн зүрх судасны кабинетэд хянагдаж байгаа зүрхний архаг дутагдалтай эмчлүүлэгчдийн мэдлэгийг үнэлэх нь” сэдвээр ОПБХ-д илтгэл тавьж, бүтээлийн номонд оруулсан.

Багануур ЭМТөв “Эрдмийн чуулган – 2019” онол практикийн бага хурлыг 2019 оны 04 сарын 26-нд зохион байгуулж чуулганд 47 эмч, мэргэжилтний 19 илтгэл ирүүлснээс 10 илтгэлийг хэлэлцүүлсэн. Үүнд:

- Дотрын тасгийн эмчлэгч их эмч Н.Очирмаа "Зүрхний архаг дутагдлын үеийн амьдралын чанар"
- Нийгмийн Эрүүл мэндийн ажилтан Д.Будханд "Дүүргийн өсвөр үеийнхний эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ дадал хэвшлийг тодорхойлсон судалгааны үр дүн"
- Эх барих эмэгтэйчүүдийн их эмч Л.Дэлгэрцэцэг, Эх баригч бага эмч Ц.Алигэрмаа нарын "Сүүлийн 5 жилд Багануур дүүрэгт бүртгэгдсэн өсөлтгүй жирэмсэн болон зулбалтын тохиолдолд үнэлгээ өгсөн нь"
- Дүрс оношилгооны их эмч Г.Одонтуул, Рентген техникч А.Батцэцэг нарын "Багануур дүүргийн иргэдийн цацрагийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлагыг үнэлсэн судалгааны үр дүн"
- Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн С.Оюунцэцэг, Хүүхдийн сувилагч Б.Алтансүвд нарын "БНЭМТ-ийн эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн цусаар дамжих халдварыг зүү хурц үзүүртэй эмнэлгийн багаж хэрэгсэлд хатгагдсантай холбон судалсан эрсдлийн судалгаа"
- Статистикийн мэргэжилтэн Б.Мөнхчимэг "Багануур дүүргийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дундах жирэмслэлт ба үр хөндөлтийн зарим асуудал"
- Мэс заслын их эмч С.Баатар-Уул, Мэс заслын сувилагч Б.Оюунцэцэг нарын "0-5 насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусламжийн мэдлэгийг үнэлэх нь"
- Шүдний эрүүл ахуйч Д.Болдмаа "Багануур дүүргийн 18-65 насны хүн амын дундах амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчний эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлох судалгаа"
- Хөнгөвчлөх эмчилгээний сувилагч П.Цэрэндэжид "Өсвөр насны эрт үеийн буюу 10-13 насны хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйн мэдлэгт хийсэн тандалт судалгаа"



МСН-ээс зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд эмэгтэйчүүдийн кабинетын бага эмч Ц.Алигэрмаа нарын **“Бүртгэгдсэн өсөлтгүй жирэмслэлт болон зулбалтын тохиолдлыг үнэлсэн байдал”** судалгааны ажил ханын пост хэлбэрээр хэлцэгдэн хураангуй номд орсон.



АШУУИС Сувилахуйн сургуулиас “Сувилахуйн түүх ба судалгаа” уриан зохион байгуулсан олон улсын сувилагчдын 5-р их хуралд ахлах сувилагч Д.Цэцэгмаа нарын “Ээлжийн ажил сувилагч нарын эрүүл мэндэд нөлөөлөх нь” сэдэвт судалгааны ажил ханын постоор хэлцэгдэж судалгааны эмхтгэл номд орсон.



Албан хаагч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр хэрэгжүүлсэн ажлууд:

2019 оны 1-р улиралд байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хороотой Хамтын гэрээгээ шинэчлэн байгуулж

- Боловсролын зэргийн нэмэгдлийг шинжлэх ухааны болон боловсролын гэж ялгалгүй нэмэгдэл олгох
- Цалинтай болон тэтгэмжтэй олгодог чөлөөний хугацааг нэмэгдүүлэх
- Сүрьеэтэй ажилладаг эмч, сувилагч, үйлчлэгч нарт 30%-ийн нэмэгдэл олгох
- Илүү цагийг 1,8 дахин, шөнийн цагийг 0,5-аар бодож олгох
- Хоолны мөнгө сард 80000 төг, унааны зардал өдрийн 1000 төгрөгөөр тус тус тооцон олгох
- Ажил мэргэжлийн аврагуудын урамшуулал
- Ур чадварын нэмэгдэл зэргийг нэмэгдүүлэн олгох
- Үйлдвэрчний эвлэлийн хороон даргыг байгууллагын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2019 оны 24-р тогтоол болон 25-р тогтоолын дагуу Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн жишигт нийцүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журмын дагуу улирал бүр үр дүнг тооцон олгож байна. Үр дүнгийн урамшууллыг:

1-р улиралд 331 ажилтанд 41.064.043₮,

2-р улиралд 315 ажилтанд 57.055.450₮,

3-р улиралд 321 ажилтанд 59.128.725₮

4-р улиралд 321 ажилтанд 46,312,885₮ нийт 4 улирлын байдлаар давхардсан тоогоор 1288 ажилтанд 203,561,103₮-ийг олгосон байна.

Эмч, сувилагч, үйлчлэгчийн ажил дүгнэх үнэлгээний хуудас:

Хугацаа	Төрөл	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр
2018 оны I кв

Хугацаа	Төрөл	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр
2018 оны II кв

Хугацаа	Төрөл	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр
2018 оны III кв

Эрүүл мэндийн ажилтанд ажилласан 5 жил тутамд нь Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралт дээр нь 1 өдрийн нэмэгдэл амралт олгож байна. Тайлант хугацаанд нийт 314 ажилтанд 1824006461 төгрөгийн цалин хөлс, 123788564 төгрөгийн унаа хоолны нэмэгдэл, олгосон.

Эрүүл мэндийн яамнаас зарласан Эмнэлгийн ажилчдын нийгмийн хамгааллыг дэмжих сарын аяны хүрээнд:

- 15,000,000 төгрөгөөр ЭМТ-ийн нийт ажилчдыг гадуур өмсөх дулаан цамцаар бүрэн хангасан.
- Эрүүл мэндийн салбарт 34 дэх жилдээ ажиллаж байгаа өрх толгойлсон эмэгтэй Дотрын тасгийн үйлчлэгч Ц.Тунгалагт 2,500,000 төгрөгийн үнэ бүхий иж бүрэн 5 ханатай гэрийг олгосон.



- Эмч, сувилагч, эмнэлгийн ажилчдын ар гэрийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан БНСУ-ын Инчён хотын Инха эмнэлэгтэй хамтран 35,000,000 төгрөгний үнэ бүхий эм, амин дэмийг үнэгүй олгож **“ГЭР БҮЛ”-ийн спортын өдөрлөг зохион байгуулж ажилласан.**



- “Чухал хүн” ТББ-тай хамтран Эрүүл мэндийн төвийн В1 давхарын 250 м/кв талбайг засварлаж, тохижуулан бялдаржуулах болон спиннингийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн.



- Долоо хоног бүрийн Лхагва гаригт 17 цагаас Нийгмийн эрүүл мэндийн төвийн зааланд нийт ажилчдын дунд нийтийн цэнгээнт бүжиг зохион байгуулж байна.



- Хэрлэн голын эрэг дээр байгууллагын эзэмшлийн 1500 м/кв талбай бүхий газрыг шийдвэрлүүлж, 8,000,000 төгрөгний үнэ бүхий 10 ханатай иж бүрэн гэрийг барьж тохижуулан, ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд анхааран ажиллаж байна.



Албан хаагчдын шагнагдсан байдал:

Тайлант хугацаанд нийт 73 ажилтан болон ахмад настанууд шагнагдсанаас төрийн одон медалиар 11, ЭМЯ-ны шагналаар 39, Нийслэлийн “Тэргүүний ажилтан” цол тэмдэгээр 3 ажилтан, НЭМГ-ын шагналаар 23 ажилтан шагнагдсан байна.

- “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар – 6
- ЭМЯ-ны “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэгээр- 17



- ЭМЯ-ны “Жуух бичиг”-ээр – 7
- НЭМГ-ын “Тэргүүний ажилтан” цол тэмдэгээр – 4
- НЭМГ-ын “Өргөмжлөл”-өөр – 3
- Дүүргийн ИТХ-ын “Хүндэт үнэмлэх”-ээр – 7
- Дүүргийн ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл”-өөр - 6
- Дүүргийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр – 7
- Дүүргийн Засаг даргын “Баярын бичиг”-ээр – 3
- Монголын сувилагчидийн нийгэмлэгийн Ард түмний талархал хүлээсэн сувилагчаар - 1
- Монголын сувилагчдийн нийгэмлэгийн Алтан гарт сувилагчаар – 2
- Сувилахуйн амьдрал төвийн Тэргүүний мэргэжилтэн хүндэт тэмдэгээр – 1
- Сувилахуйн амьдрал төвийн аврахуйн үйлстэн хүндэт тэмдэгээр – 4
- Монголын залуучуудын холбооны “Тэргүүний залуу алтан медаль”-иар 3 хүн
- Дүүргийн ЗД-ын Алтан чагнуур шагналаар 2
- Г.Энхцэцэг Сувилахуйн амьдрал төвөөс зохион байгуулсан сувилахуйн туслах нарын ур чадварын уралдаанд "Шилдэг сувилахуйн туслах"-аар шалгарсан.



Тус онд Эрүүл мэндийн төвийн хэмжээнд 31 ажилтанд 84 хоногын цалинтай чөлөө, 48 ажилтан 1895 хоногын цалингүй чөлөө олгосон байгаа нь 2018 онтой харьцуулвал цалинтай чөлөө 12 хоногоор, цалингүй чөлөө 575 хоногоор өссөн үзүүлэлтэй байгаа нь эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын нийгмийн баталгааг анхааран ажиллаж буйн нэг илрэл юм. Үүнээс: Монгол Улсын Засгийн Газрын чиглэлийн дагуу Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед хүүхэд нь өвдсөн болон асрах шаардлага гарсан 6 эмч, сувилагч, эмнэлгийн ажилтанд 25 хоногийн цалинтай чөлөө олгосон байна.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх буюу хугацаат үзлэгт хамруулсан байдал:

Багануур дүүргийн ЭМТөв нийт 314 ажилчидтай. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх бүрдмэл үзлэгт 307 ажилтан хамрагдаж, үзлэгийн хувь 97,7% байна.

- Нийт ажилчдын 85,3%-ийг эмэгтэй ажилчид, насны хувьд 61,4%-ийг 40 хүртэлх насны ажилчид эзэлж байгаа бөгөөд ажилчид насны хувьд залуужиж байна.
- Ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт 97,7% байгаа нь өмнөх оныхоос нэмэгдсэн, түвшинтэй ойролцоо байна.

Эрүүл ажилтны тоо 7,5%, өвчлөл илэрсэн ажилчдын тоо 92,5% болж, өвчлөл нэмэгдэх хандлагатай.

- Нэг ажилтанд илрэх 3 хүртэлх өвчлөлийн эзлэх хувь 60,2% болсон.
- Өвчлөлийг судалж үзэхэд дотор, нүд, чих хамар хоолойн эмгэгүүд зонхилж байна.
- Бие бялдарын сорилд хэвлийн хүч, тэнцвэр, тэсвэр гэсэн үзүүлэлтүүд хангалтгүй
- Цусны даралт ихэсдэг 25 ажилчин байгаа бөгөөд эдгээр хүмүүс өрхийн эмчийн болон нарийн мэргэжлийн эмчийн байнгын хяналтанд байж даралтыг тогтмол үзүүлэн хянуулж, даралт бууруулах эмийг эмчийн заавраар зохих тунгаар хэрэглэх, мөн ажил амралтыг зөв зохицуулах шаардлагатай байна.
- Элэгний архаг үрэвсэл 12 хүнд илэрсэн ба эмчийн хяналтанд байж, хоол болон хөдөлгөөний дэглэмийг баримтлан, 3 сард нэг удаа элэгний үйл ажиллагааг хянуулах нь зүйтэй.
- Чих хамар хоолойн кабинет 132 хүнийг хяналтанд авч эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гаргасан.
- Ходоодны үрэвсэлтэй 60, бөөрний архаг үрэвсэлтэй 30 ажилчид байна.
- Мэдрэлийн тогтолцооны эмгэгтэй 103 хүн байгаа бөгөөд эмчлэн эрүүлжүүлэх хэрэгтэй.
- Элэгний В,С вирус 47 ажилчдад илэрсэн ба эмчийн хяналтанд байж, 3 сард нэг удаа элэгний үйл ажиллагааны шинжилгээг өгөх нь зүйтэй.
- Жингийн илүүдэл буюу таргалалттай 145 ажилтан байгаа бөгөөд бие бялдарын сорилд хамрагдагсдын 47,2 %-ийг эзэлж байна. Эдгээр хүмүүс эмчийн тогтмол хяналтанд байж хоолны дэглэм баримтлан, зөв хооллож, жингийн илүүдлийг багасгах ба хасах шаардлагатай байна. Ялангуяа таргалалтын II ба III зэрэгтэй 17 ажилтан хөдөлгөөнөөр тогтмол эрчимтэй хичээллэн жингээ илүүтэйгээр хасах хэрэгтэйг анхааруулж байна.

Цаашид авах арга хэмжээ:

- Эрүүлжүүлэх ажил зохион байгуулах
- Витамин Д-г нөхөх эмчилгээ хийх
- Харааны шилийг тогтмол зүүх
- Зөв хооллолтонд суралцах
- Ажлын байрны дасгал хийж хэвших
- Дасгал хөдөлгөөнөөр хичээллэх
- Стресс менежментэд суралцах гэх мэт ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

3.5 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

Тайлант хугацаанд эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой талархал, санал, хүсэлт, өргөдөл, гомдол 99 ирснээс биелэлт 100% байна.

Саналын тоо – 1


Шийдвэрлэлтийн хувь – 100%

Гомдлын нийт тоо – 10

Шийдвэрлэлтийн хувь – 100%
Хүсэлтийн тоо – 15
Шийдвэрлэлтийн хувь – 100%
Талархалын тоо – 73
Хувь – 100%

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:
“БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”

Багануур Эрүүл мэндийн төв – Facebook нээлттэй групп, Багануур Эрүүл мэндийн төв – Facebook page хуудас болон www.bnemn.ub.gov.mn сайт, байгууллагын мэдээллийн самбарт Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааны стратеги зорилт, зорилго түүний үйл ажиллагааны биелэлт, тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны тайланг тухай бүр шинэчлэн байршуулж байна.




Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн болон өргөдөл, гомдол хүлээж авах 15 удирдах ажилчдын мэдээллийг Багануур Эрүүл мэндийн төв – Facebook нээлттэй групп, Багануур Эрүүл мэндийн төв – Facebook page хуудас болон www.bnemn.ub.gov.mn сайт, байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.



Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудсууд болон мэдээллийн самбар байгууллагын угтах хэсгийн LED дэлгэцэнд тогтмол байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.

Байгууллагын төсвийн төлөвлөгөө, мэдээ, тайлан, гүйлгээ, хөрөнгө гаргахтай холбоотойгоор гарсан тушаал шийдвэр, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгүүд, хүний нөөцийн мэдээллийг шилэн дансны мэдээлэл тавих хугацааны дагуу байгууллагын вэб хуудсанд сар бүр байршуулж байна. Тайлант хугацаанд төсөв, орлого зарлагын 29 мэдээг байршуулсан.

Байгууллагын вэб сайтын ил тод байдал цэсэнд статистикийн мэдээ, мэдээллийг сар бүр шинэчлэн тавихаас гадна ханын самбар байршуулан иргэдэд мэдээлэл хүргэж байна.



2010-2018 оны хоорондох дүүргийн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтийн номыг 2019 онд хэвлүүлж, хамтран ажилладаг байгууллага, аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр хангаж ажиллалаа.



Нийслэлийн Эрүүл мэндийн газрын статистик мэдээллийн хэлтэсээс 2019 оны 6 сард харъяа байгууллагуудын вэб сайтад тавигдсан статистик, мэдээ мэдээлэлд хяналт үнэлгээ хийхэд “ХАНГАЛТТАЙ” хэмжээнд үнэлэгдсэн.

- Байгууллагын 1985 оноос 2019 оны тушаалуудыг сканнердан цахим архив үүсгэх бэлтгэл ажлыг ханган, Нийслэлийн



архивын газарт хүргүүлээд байна.

- Вэб сайтын мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн баяжуулж вэб сайтад тавигдах MNS 6285:2011 стандартыг мөрдлөг болгон байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг <http://www.bnemn.ub.gov.mn/> цахим хуудас, “Багануур дүүргийн эрүүл мэндийн төв” facebook хуудсаар ил тод, нээлттэй, шуурхай хүргэн ажиллаж байна.
- Вэб сайтын мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн баяжуулж вэб сайтад тавигдах MNS 6285:2011 стандартыг мөрдлөг болгон байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг <http://www.bnemn.ub.gov.mn/> цахим хуудас, “Багануур дүүргийн эрүүл мэндийн төв” facebook хуудсаар ил тод, нээлттэй, шуурхай хүргэн ажиллаж вэб сайтанд 165 мэдээ, фэйсбүүк хуудсанд 225 мэдээ, мэдээллийг оруулсан байна. Нийт вэб хуудсаар орж мэдээлэл авсан хандалтын тоо 33409 байна.
- Дүүргийн орон нутгийн “Сүлжээ-3 телевиз, FM 104.5 радиогоор цаг үеийн мэдээ, мэдээлэл, сургалт, өдөрлөгийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн зөвлөгөөг 64 удаа хүргэн ажиллалаа.



ЭМТ-ийн 15 тасаг нэгжийн ахлах сувилагч, стационарын 9 тасгийн сувилахуйн пост, компьютераар хангагдан дотоод сүлжээнд холбогдон EHealth программд өвчний түүх нээх, нарийн мэргэжлийн кабинетад үзүүлэх үйлчлүүлэгчийн захиалга нэрийг оруулж товлот цаг авах зэрэг үйлчилгээг цахимаар хийж байна.

Эмнэлэг хяналтын комиссын хурлыг 42 удаа хуралдуулж, 3118 хүний асуудлыг шийдвэрлэсэн. ХЧА-ыг шинээр 82 хүнд тогтоож, сунгалтыг 425 хүнд хийж, 49 хүнийг цуцалсан. ЭМСайдын 2012 оны 04 сарын 20-ны 129 тоот тушаал “Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журам”-ын дагуу үнэ төлбөргүй эмийг 249 хүнд олгосон. Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас 13А маягтаар 1327 хүнийг дээд шатлалын эмнэлэгт илгээж үзлэг, оношлогоо, эмчилгээнд хамруулсан. Байнгын асаргаа шаардлагатай иргэнээр 136 хүнийг тодорхойлж, асран хамгаалагчийн сунгалтыг хийсэн. Өвчний учир ажлаас чөлөөлөх актыг 465 хүнд тодорхойлсон. Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг 385 хүнд гаргасан.

Байгууллагын төсвийн төлөвлөгөө, мэдээ, тайлан, гүйлгээ, хөрөнгө гаргахтай холбоотойгоор гарсан тушаал шийдвэр, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэгүүд, хүний нөөцийн мэдээллийг шилэн дансны мэдээлэл тавих хугацааны дагуу, шилэн

данс болон байгууллагын вэб хуудсанд сар бүр байршуулж байна. Тайлант хугацаанд төсөв, орлого зарлагын 26 мэдээг байршуулсан.

Байгууллагын 1985 оноос 2019 оны тушаалуудыг скайнердан Цахим архив үүсгэх бэлтгэл ажлыг ханган, Нийслэлийн архивын газарт хүргүүлэн цахим архив үүсгүүлсэн.

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв нь дараах программ хангамжуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

№	Ашиглагдаж буй программ
1	E-health
2	Mn obstetrics
3	erp ulaanbaatar-Бичиг хэрэг хүний нөөц
4	erp ulaanbaatar-өргөдөл гомдол
5	Oculus санхүүгийн программ
6	Payroll санхүүгийн программ
7	Pharmacy эмийн сангийн программ
8	health.gov.mn - даатгалын мэдээ
9	health.gov.mn - элэг бүтэн
10	health.gov.mn - эмийн жор бичих
11	health.gov.mn - у/с үзлэг
12	h-info
13	Ewar 2.0 –Халдварт өвчнийг эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ
14	Screening.mn -Хавдрын эргэн дуудах тогтолцооны бүртгэлийн программ
15	Flu.mn – томуугийн харуулан тандалтын мэдээний бүртгэл
16	Cancer.mn – Хавдар өвчнийг бүртгэх, мэдээлэх, хянах
17	Ubhealth.mn – Архины хордлого, хүлээгдлийн мэдээ, төрөлтийн мэдээ
18	E-Health.gov.mn – Төрөлт, нас баралт, Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн тайлан мэдээ
19	ENEMUT.MN- төрсөн хүүхдийн мэдээ
20	cardiocenter.telemedicine.mn/ Зүрх судасны секторын тохиолдол бүртгэл, хяналт
21	XPLATFORM9.2_SetupEngine.cab Төрийн өмчийн харилцааны газрын “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем” – ийн хүрээнд хэрэгжиж буй програм
22	tubis.mn Сүрьеэгийн тохиолдол бүртгэх програм
23	66.181.170.27:8080/nud/ ЭХЭМҮТөвийн хүүхдийн нүдний өвчлөлийн тохиолдол бүртгэх
24	Тархины цахилгаан бичлэгийн програм
25	Хавдарын тохиолдол бүртгэх програм
26	Scope Pro V.2 Ходоодны дурангийн програм
27	vssm дархлаажуулалтын программ
28	hepsupdate.ontime.mn мэдээлэл тоног төхөөрөмж болон эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэх

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ:

Энэ оны 10 сарын байдлаар сэтгэл ханамжийн судалгааг нийт 9 удаа авч нийт 1490 хүн хамруулсан. Үүнд:

1. Байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, удирдлага, зохион байгуулалт, тэгш байдал, ашиг сонирхолын талаар хэвтэн эмчлүүлэгчдийн тасгаас 300 үйлчлүүлэгч хамрагдсан.
2. Байгууллагын дэмжлэгт удирдлага, хүний нөөцийн хөгжих боломж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, байгууллагын соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, ажлын байрны аюулгүй байдал, дэмжлэгт орчны талаар эмч, ажилчдаас 440 ажилтан хамрагдсан.
3. Байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, удирдлага, зохион байгуулалт, тэгш байдал, ашиг сонирхолын талаар амбулаторийн тасгаар үйлчлүүлж буй 300 иргэд, үйлчлүүлэгчид хамрагдсан.
4. Өрхийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, удирдлага, зохион байгуулалт, тэгш байдал, ашиг сонирхлын талаар 300 иргэд үйлчлүүлэгчид
5. Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн:

	Үйлчлүүлэгчийн эерэг сэтгэл ханамжийн хувь	Эмч, эмнэлгийн ажилчдын эерэг ханамжийн хувь
2018.10 сарын байдлаар	83%	80%
2019.10 сарын байдлаар	87%	81%

ТАВДУГААР БҮЛЭГ: “БУСАД МЭДЭЭЛЭЛ”

5.1 Байгууллагын харъяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл

МУ-ын ЗГ-ын 2011 оны 311 тоот тогтоолын дагуу аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.

2019 онд Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний орон тооны мэргэжилтэн болон Чанарын алба, сувилахуйн албаны дэргэд орон тооны болон орон тооны бус дотоод хяналтын зөвлөлүүд ажиллаж байна.

Тайлант хугацаанд Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтний зүгээс Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2019 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, НМХГ-ын 2019 оны 02-01/77 тоот удирдамжийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл ахуйн тухай, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Цөмийн энергийн тухай хуулиуд, түүнтэй холбогдох дүрэм, журам, тушаалын холбогдох заалтуудын хэрэгжилтийг хянах зорилгоор дараах дотоод хяналт шалгалтыг хийсэн. Үүнд:

1. НМХГ-ын 2019.02.19-ны өдрийн “Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай удирдамжид заагдсан хяналтын хуудсуудаар дотоод хяналт хийхэд:
 - 3.28.1 кодтой “Түргэн тусламжийн төвийн оношлогоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах” хуудсаар шалгахад хэрэгжилтийн хувь **76%**
 - 4.2 кодтой “Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах” хяналтын хуудсаар Ахлах нягтлан бодогч Б.Наранцэцэг, Цалингийн нягтлан бодогч Д.Чимгээ нарыг хамруулан. **94,3%**
 - 4.8 кодтой “Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийн зарцуулалтыг шалгах” хяналтын хуудсаар Эрүүл мэндийн даатгал хариуцсан эмч Л.Нэргүйг хамруулан шалгахад хэрэгжилтийн хувь **94%**
 - 4.6 кодтой “Хөдөлмөрийн харилцааг шалгах” хяналтын хуудсаар Хүний нөөцийн менежер Б.Оюунбаатарыг хамруулан шалгахад хэрэгжилтийн хувь **100%**
 - 4.1.2 кодтой “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах” хяналтын хуудсаар ХАБЭА хариуцсан ажилтан Ч.Оюунзулыг хамруулан шалгахад хэрэгжилтийн хувь **86,7%**
 - 10.2 кодтой “Рентген оношлогооны цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах” хяналтын хуудсаар Рентгений их эмч Г.Одонуул, техникч А.Батцэцэг, Мөнхтулга нарыг хамруулан шалгахад хэрэгжилтийн хувь **83,4%** тус тус байв.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ауйн тухай хууль, түүнтэй холбогдох дурэм, журам, тушаалын холбогдох заалтуудын хэрэгжилтийн байдалд ХАБЭАжилтан Ч.Оюунзултай хамтран

- Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн ажилтнуудын 2016, 2017, 2018 оны урьдчилан сэргийлэх үзлэгийн хуудас, ХЧТА-ын бүртгэл, эрүүлжилтийн байдлын тайлан
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 2016, 2017, 2018 оны жилийн эцсийн тайлан, тоон мэдээлэл зэрэг баримт
- 4.1.2 кодтой “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах” хяналтын хуудас зэргийг ашиглан дотоодын хяналтыг хийж дараах зөвлөмжийг өгөөд байна.

4.1.2 кодтой “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах” хяналтын хуудас

- ХАБЭА асуудал хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан батлуулж мөрдүүлэх
- Аюулыг мэдээлэх хуудсаар мэдээллийг бүртгэдэг системийг нэвтрүүлэх
- Эрсдлийн гадаад, дотоод үнэлгээг хийх
- Ажлын хувцас хамгаалах хэрэгслийн нэр төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалт, журмыг боловсруулан мөрдөх
- Даралтад сав бусад тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортыг тухай бүрд нь хөтөлж хэвших

ХАБЭА-н тухай хуулийн 14 дүгээр зүйлийн хэрэгжилтийг Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн ажилтнуудын 2016, 2017, 2018 оны урьдчилан сэргийлэх үзлэгийн хуудас, ХЧТА-ын бүртгэл, эрүүлжилтийн байдлын тайлан, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 2016, 2017, 2018 оны жилийн эцсийн тайлан, тоон мэдээлэл зэрэг баримтад үндэслэн хянан судлахад:

- Жил бүрийн урьдчилан сэргийлэх үзлэгт өмнөх онд хийгдээгүй оношлогоо, шинжилгээний багцыг оруулах тал дээр анхаарах /Хавдарын маркер болон өмнөх онд хийгдээгүй зарим нэгэн шинжилгээний үзүүлэлт, бусад г.м/
- Ажилтан бүрт өөрийн эрүүл мэндээ хамгаалах үүргээ биелүүлэх, амьдралын зөв дадал эзэмших мэдлэг боловсролыг олгох, байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэх /илүүдэл жинтэй ажилтнуудын тоо нэмэгдэж байгаа, таргалалттай ажилтнуудын тоо буураагүй, шүдний өвчлөл, амьсгал зүрх судасны өвчлөл өндөр байгаа зэрэг/
- Өвчлөл илэрсэн тохиолдол бүрийг эмчийн хяналтанд эмчлүүлэх

3. Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиуд, Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай” 380 тоот тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны “Төлбөрийн хэмжээ, жагсаалт, өртгийн жин, журам батлах тухай” 19 тоот тогтоол, түүнтэй холбогдох дурэм, журам, тушаалын холбогдох заалтуудын хэрэгжилтийг

- Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын 1-3 дугаар сарын нэхэмжлэлийн баримт
- Эрүүл мэндийн төвийн Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур татан авалтын бүртгэл

- Эрүүл мэндийн төвөөс иргэдэд үзүүлж буй оношлогоо шинжилгээний жагсаалт, бүртгэлийг ашиглан дотоод хяналтыг хийж дараах зөвлөмжийг өгөөд байна. Үүнд:

1. Мэс ажилбар хийдэг амбулаторийн ажилбайрууд үнэлэгддэггүй. Түүнд хөрөнгө зардал ихээр зарцуулагддаг байна. Иймээс ажилбар, процетуруудыг ЭМД-аас тусад нь санхүүжүүлэх боломжийг судлах Үүнд: Мэс засал, Шүд, Нүд, Чих хамар хоолой, эмэгтэйчүүд гэх мэт

2. Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээний амбулаторийн үзлэг, эмчилгээ, гемодиализ эмчилгээ Эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авдаггүй байна.

3. Хяналт шинжилгээгээр гарсан ЭМД-ын сангаас санхүүжилт авдаггүй оношлогоо, шинжилгээнүүдээс ЭМД-ын сангаас санхүүжих боломжтой шинжилгээ байгаа эсэхийг судлан дүүргийн болон ЭМД-ын ерөнхий газарт саналаа явуулах.

Чанар, сувилахуйн албаны зүгээс: 2019 онд дараахь хяналтын хуудсыг шинээр боловсруулан ашиглаж байна. Үүнд: Чанарын болон сувилахуйн алба хамтран тасаг, нэгж бүрийн чанарын ажлыг эхний 3 сард 12 асуулттай чеклистээр, 4-р сараас 14 асуулттай чеклист боловсруулан сар бүр хянаж, ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулан ажиллаж хэвшсэн. Үүнээс онцлох хийсэн дэмжлэгт хяналтаас дурдахад:

- ЯТТ-ийн тасгийн эмч Г.Анхболдтой хамтран 2019 оны 1,2,3 сард ЯТТ 103-ийн давтан дуудлаганд хяналт үнэлгээг хийж ажилласан. Нийт давтан дуудлага 216, 2 удаа – 48, 3 удаа – 25, 4 удаа – 7, 5 удаа – 2, 7 удаа – 1 тохиолдолд дуудсан байна.
- Багануур дүүргийн ЭМТ-ийн чанарын албаны дарга Ц.Балжидмаа, цусны салбар төвийн эмч О.Мандах нар хамтран 2019 оны 1, 2 улиралд тасаг, нэгж болон хүнд өвчтөнд цус цусан бүтээгдэхүүн сэлбэсэн 8 өвчний түүхийг түүвэрлэн авч дэмжлэгт хяналтыг хийлээ. Хяналтыг тусгай боловсруулсан хяналтын хуудсаар дүгнэж үзэхэд дундаж үнэлгээ нь 61,4% -тай дүгнэгдсэн ба хангалтгүй байгаа зөрчлийг илрүүлж, ЦСЗЗ –ийн гишүүд дүгнэлт хийж холбогдох зөрчил дутагдлыг арилгах тал дээр төлөвлөгөө өгч, үр дүнг тооцон ажиллаж байна.
- Чанарын алба, сувилахуйн алба, халдвар хяналтын баг хамтарсан дотоод хяналтыг төрөх, мэс засал эмэгтэйчүүд, нярайн тасгуудад 2019 онд нийтдээ 6 удаа хийж ажилласан. Хяналтаар илэрсэн сайн тал болон дутагдалтай талыг тухай бүрт танилцуулан дутагдлыг арилгах талаар үүрэг өгч биелэлтийг шалгаж ажиллав.
- Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11-р сарын 450 тоот тушаал, Эрүүл мэндийн бүртгэлийн маягт СТ- 1, 1Б, СТ-3, 7 зэрэг өвчний түүхийг стандартын дагуу хөтөлж байгаад хяналт үнэлгээг улирал тутамд хийж тухай бүрд нь тасаг нэгж, хувь хүнд нь гарсан зөрчлийг танилцуулж дутагдлыг засах тал дээр анхааруулж ирсэн. Үүнд: 05.02-ноос 05.13 –ны хооронд 30 ширхэг өвчний түүх хөтлөлтөнд түүвэр аргаар хяналт үнэлгээг хийлээ. Хяналтыг тусгай боловсруулсан хяналтын хуудсаар дүгнэж үзэхэд дундаж үнэлгээ нь 87,6% -тай дүгнэгдсэн байна. Нийтлэг 10 зөрчил илрүүлж зөрчлийг арилгах талаар төлөвлөгөө гаргаж ажиллав. Мөн хүүхдийн тасгийн өвчний түүхийн стандарт

мөрдөлт болон төрөх тасгийн антибиотекийн хэрэглээнд хяналт үнэлгээг хийж гарсан зөрчлийг танилцууллаа.

- БНЭМТ-ийн гал тогоонд тусгайлан бэлтгэсэн үнэлгээний хуудсын дагуу халдвар судлаач эмчтэй хамтран шалган, илрүүлсэн зөрчлийг арилгах тал дээр менежер Алтанзулд үүрэг өгч ажилласан.
- ЭМТ-ийн ЖЗӨК-ын үйл ажиллагаанд чанарын дотоод дэмжлэг хяналт 2 удаа дараах чиглэлүүдээр хийсэн. Үүнд: жирэмсэний хяналтын үеийн зөвлөгөө өгөлтийн байдал, жирэмсний хяналтын өрөөнд байх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн бэлэн байдал, жирэмсэний хяналтын байдал, жирэмсэний хяналтын үзлэгийг ажиглалтаар
- Монгол улсын ЭМС-ын 2014 оны 263 тоот “Алсын дуудлага, явуулын эмнэлгийн талаар авах арга хэмжээний тухай” тушаалыг үндэслэн чанарын алба, аж ахуй үйлчилгээний алба, дотоод хяналтын алба, сувилахуйн алба, халдвар хяналтын алба хамтарсан дотоод хяналтыг түргэн тусламж-103-ийн автомашины алсын болон ойрын дуудлаганы бэлэн байдлыг хангасан байдалд үнэлгээг хийж ажилласан бөгөөд нийт 16 зөрчил илрүүлэн ЯТТ-ийн жолооч тус бүр дээр гарсан зөрчлийг нарийвчлан судалж ЯТТ-ийн тасгийн эрхлэгч Н.Оюунбат болон механик Н.Нарандорж нарт үүрэг өгч ажиллав.
- Халдвар судлаач эмч С.Одсүрэн эмчтэй хамтран дархлаажуулалтын нэгж дээр дэмжлэгт хяналтыг хяналтын хуудсаар үнэлэхэд 16 оноо буюу 94,1%-тай байсан.
- ХЕМэргэжилтэн дүүргийн 4 хорооны ӨЭМТүүд дээр хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгах үүрэг өгч ажилласан.
- Төрөх тасагт нярай хүүхдэд тусламж үйлчилгээг стандарт, технологийн дагуу үзүүлж байгаа эсэх, ЭМС-ын А/355 тоот тушаалын хэрэгжилтийг үнэлэх, тусламж үйлчилгээний алдаа дутагдлыг илрүүлэн эрсдэлээс сэргийлэх зорилгоор хяналтыг хийв. Үүнд:
 - Амьсгалахгүй нярайд НЭҮНШТ үзүүлэх ур чадварыг шалгахад 95%,
 - Амьсгалж буй нярайд НЭҮНШТ үзүүлэх ур чадвар 95%,
 - Нярайн сэхээн амьдруулах тусламж үзүүлэх байдал 90%
 - Нярайн нэн шаардлагатай суурь тусламж үзүүлэх чадвар 94%,
 - Нярайн түүх бичилт 95%,
 - Дутуу бага жинтэй нярай, өвчтэй нярайд үзүүлэх тусламж 87%,
 - Эмчилгээтэй нярайн сувилахуйн тусламж 92%,
 - Нярайн нэн шаардлагатай суурь тусламж үзүүлэх чадвар 100% тус тус үнэлэгдсэн ба илэрсэн зөрчлийг танилцуулж 14 хоногийн хугацаанд арилгах үүрэг өгч гарсан зөрчлийг арилгав.
- ЭМС-ын 2013 оны 450 тоот тушаалын Эрүүл мэндийн бүртгэлийн маягт СТ-32-ын хэрэгжилтийг түргэн тусламжийн үйл ажиллагаанд хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэхэд дундаж үйлчилгээ 75,7% байна.
- ЭМС-ын 2014 оны 187 тоот тушаалын 4 хавсралтын дагуу Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх арга хэмжээг үнэлэх үнэлгээний хуудсаар ЭМТ-ийн нийт 16 тасаг, нэгжийн ажилчдын дунд тандалт үнэлгээг хийв. Дундаж үнэлгээ 68-90% байна.

- ЭМС-ын 2013 оны 450 тоот тушаал, эрүүл мэндийн бүртгэлийн маягт СТ32 дагуу эрэмбэлэн ангилах яаралтай тусламжийн хуудсанд 2019.07.01-2019.07.31 хооронд 1 сарын хугацаатай тандалт хийв. Үүнд:
 - Дотор, мэдрэлийн сектор нийт 9 эмчийн хуудас шалгагдсан бөгөөд дундаж үзүүлэлт-86,8%
 - Мэс заслын сектер нийт 7 эмч шалгагдсанаас насанд хүрэгчдийн эрэмбэлэн 84,2%,
 - Хүүхэдийн эрэмбэлэн 81,7%
 - Төрөх нийт 5 эмч шалгагдсан бөгөөд дундаж үзүүлэлт 93,6%
 - ЯТТ-ийн тасаг 75,5-85.7%-тай үнэлэгдсэн байна.
- ЭМТ-ийн чанарын албанаас Энэрэлт-Өлзий, Энх-Өрх, Ач-Элбэрэл, Биваангирд ӨЭМТөвүүдэд хүүхдийн тусламж үйлчилгээтэй холбоотой хяналтыг нярай хүүхдийн гэрийн эргэлтийн чанар, хүүхдийн яаралтай тусламжийн бэлэн байдал, ӨЭМТ-ийн хүүхдүүдийн диспансерын хяналт, 15. 2019оны 10-р сарын 21 нд Энэрэлт-Өлзий, Энх-Өрх, Ач-Элбэрэл, Биваангирд ӨЭМТ-үүдэд 10ширхэг өвчний түүх хөтлөлтөнд түүвэр аргаар хяналт үнэлгээг хийлээ. Хяналтыг тусгай боловсруулсан хяналтын хуудсаар дүгнэж үзэхэд дундаж үнэлгээ нь 81,7 % -тай дүгнэгдсэн байна.
- ЭМТ-ийн ЖЗӨК-ын хяналтанд байдаг жирэмсэн эхчүүдийн сэтгэл ханамжийн судалгааг 2019.10.23-нд, кабинетын үйл ажиллагаанд чанарын дотоод дэмжлэгт хяналтыг 2019.10.25-нд дараах чиглэлээр чеклистээр дүгнэж үзлээ.
 - Жирэмсэний хяналтын үеийн зөвлөгөө өгөлтийн хяналтын байдал
 - Жирэмсэний хяналтын өрөөнд байх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн бэлэн байдал
 - Жирэмсэний хяналтын байдал
 - Жирэмсэний хяналтын үзлэгийг ажиглалтаар
 - ЖЗӨК-ын сувилагчийн үйл ажиллагааг тус тус шалгалаа.
- Эрүүл мэндийн төвийн хүлээн авах, хүүхэд, нярай, халдвартын тасгуудад 2019.10.16-17ны өдрүүдэд байгууллагын чанарын алба, халдвар хяналтын алба, сувилахуйн алба хамтран хүүхэд нярайн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хяналтын хуудсаар үнэлж арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.
- Энэрэлт-Өлзий, Биваангирд, Ач-Элбэрэл, Энх-Өрх өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2019.10.21ны өдөр байгууллагын чанарын алба, сувилахуйн алба хамтран хүүхэд нярайн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хяналтын хуудсаар үнэлэхэд ABCD шүүгээ байхгүй, яаралтай шкаф болон яаралтай биксэндээ байрлуулсан байсан. ЭХЭМҮТөв НЭМГ-аас гарсан удирдамж зааврийн дагуу ABCD шүүгээнд байх эм эмнэлгийн хэрэгсэлийг эмх цэгцтэй байршуулах талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. Хяналт үнэлгээ хийсэн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 7 хоногийн хугацаанд дахин бэлэн байдлыг хангах үүрэг өгч ажилласан.

Ижил мэргэжилтний үнэлгээ: ЭМС-ын 2012 оны 274 дугаар тушаал Удирдамж, загвар батлах тухай “Эрүүл мэндийн байгууллагад ижил мэргэжилтний үнэлгээ хийх заавар”-ын хоёрдугаар хавсралтын дагуу байгууллагын хэмжээнд ижил мэргэжилтний үнэлгээг хийн ажиллаж байна.

Тасаг, нэгжийн эмч нар сар бүр 7 хоногт 1 удаа өвчний түүх, амбулаторийн картанд ижил мэргэжилтний үнэлгээг хийж тогтмолжоод байна.

Ижил мэргэжилтний үнэлгээний нэгтгэл, дүгнэлтийг тухайн тасгийн эрхлэгч гарган дараа сарын 5 ны дотор чанарын албанд өгдөг.

5.2 Санхүүжилт, хөрөнгө оруулалт болон байгууллагын тохижилт, үйлчилгээг сайжруулах чиглэлээр хийсэн ажил, үр дүнгийн талаар

2019 оны эхний 11 сарын байдлаар улсын төсвийн санхүүжилт 100 %, НДСангийн санхүүжилт 90.66 %, өөрийн орлогын төлөвлөгөө 103,6%-ийн гүйцэтгэлтэй байна.

№		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
1	Эрүүл мэндийн даатгалын сангаас	3 425 527.0	3 170 383.5	255 143.5
2	Улсын төсвөөс	2 458 630.0	2 458 630.0	0
3	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	68 894.1	72 797.1	-3 902.9
Нийт		5 953 051.1	5 701 810.5	251 240.6

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 92,55 %-ийн гүйцэтгэлтэй байгаа нь дараах үндэслэлтэй. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг дараа сард нь гүйцэтгэл нь гарч нэхэмжилдэг болохоор төлөвлөгөөнөөс сараар хоцорч санхүүжилт орсон.
- Өөрийн орлогын санхүүжилт 105,7%-ийн гүйцэтгэлтэй байгаа нь байгууллагуудын урьдчилан сэргийлэх үзлэг, түрээсийн орлогоор нэмэлт орлого олсон.
- 2017 оны эцсээр 1 түрээслэгчийн 3,503,6 мянган төгрөгийн түрээсийн авлагатай байсан нь барагдаагүй.
- 2019 оны эхний 10 сарын байдлаар 4 түрээслэгчийн 17 479,5 мянган төгрөгийн түрээсийн, 255 143.5 мянган төгрөгийн ЭМД сангийн санхүүжилтийн авлагатай байна.

Тайлант хугацаанд ерөнхий тендерээр 25 нэр төрлийн эм тариа 110,243,250₮-ний, 2 нэр төрлийн эмнэлгийн хэрэгслийг 39,928,000₮-өөр тус тус журмын дагуу тендерт оролцон татан авч эмчилгээ үйлчилгээндээ ашиглаж байна. Мөн НЭМГ-ын тендерт 33 багцын 594,469,384₮ /сард 49,539,115₮ нийт 61,470,053₮/ эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авахаар төлөвлөгдөөд байна.

Дулааны зардалд 20 196,2 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 7 571,1 мянган төгрөгийн урсгал засварын зардалд 1 630,6 мянган төгрөгийн өртэй байсныг төсөвт тодотгол хийж өрийг барагдуулсан, энэ нь цэвэр усны хэрэглээ

өссөн, дулааны зардал 1-2-р сард маш өндөр гарсан. Цалингийн зардалд 78 579,9 мянган төгрөгийн өглөгтэй байгаа нь 1-р сард цалин нэмэгдсэн, томуугийн дэгдэлтийн үед нэмэлтээр хүүхдийн эмч, сувилагч нарыг илүү цагаар ажиллуулсан, ээлжийн амралтын цалин зэрэгтэй холбоотой цалингийн зардал өссөн.

ЭМТ-ийн өргөтгөл /төрөх тасаг/-ийн барилгыг улсын төсвийн 2,4 тэрбум төгрөгөөр барихаар төсөвт сууж барилгын зураг төсвийг “ЭМ ЭС ЭЛ” ХХК гүйцэтгэж төсвийн хуваарийн дагуу 2019 онд хийгдэх 1,4 тэрбум төгрөгний ажлын гүйцэтгэгчээр "Өгөөмөр баян дэнж" ХХК шалгарч 2019.10.29-ны өдрөөс ажлыг эхлүүлсэн.



ЭМТ-ийн төв корпусны арын хэсэгт Нийслэлийн хөрөнгө оруулалт 1,5 тэрбум төгрөгөөр 5200 м/кв шинэ авто зам, 5400 м/кв сэргээн засварлах авто зам, 410 м/кв авто зогсоол, 16200 м/кв талбайд зүлэгжүүлэлт засвар, тохижилт, шинэчлэлийн ажлыг хийлээ.



Нийслэлийн 120 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар төв корпусын барилгын хойд талын гадна пасадны дулаалгын ажлыг хийж гүйцэтгэлээ.



ЭМТ-ийн яаралтай тусламжийн үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлын хүрээнд 2019 онд НЭМГ-ын хөрөнгө оруулалт /30 сая.төг/-аар Түргэн тусламж-103-ийн хэсгийн байр талбайн засвар тохижилтыг бүрэн хийж стандартын шаардлага

хангасан байранд бие даан, автограшийн хамтаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Төдийгүй Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Түргэн тусламж-103-ийн зориулалтын иж бүрэн 1 автомашин, Нийслэлийн түргэн тусламжийн төвөөс




балансаас балансад шилжүүлэн 1 автомашин, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5-р хорооны “Ач элбэрэл” өрхийн эрүүл мэндийн төвд Prius-30 маркийн 1 автомашин, нийт Багануур дүүргийн эрүүл мэндийн салбар **түргэн тусламжийн 3 автомашинаар парк шинэчлэл хийлээ.**



Манай эмч мэргэжилтнүүд өөрийн санаачлагаар Дэээрэт ОУ-ын байгууллагад төсөл бичсэний үр дүнд, Дэээрэт ОУ-ын байгууллага /75%/, дүүргийн ЗДТГ /25%/-ын хөрөнгө оруулалтаар **Нярайн тусламж, үйлчилгээг сайжруулах** 23,260 сая.төг-ний тоног төхөөрөмжийг 2019 оны 3 сард хүлээн авлаа. Үүнд:

1. Нярай дулаацуулах ор 1 ш
2. Тарианы шахуурга 2 ш
3. Хяналтын монитор 2ш
4. Пульсоксиметр 6ш
5. Хүүхдийн ларингоскоп 1 ш
6. Сорох төхөөрөмж 2ш

Үйлчилгээний ажилтнуудаа цэвэрлэгээний тэргэнцэрээр хангасан. Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ы хүрээнд байгууллагынхаа нүүр царай нь болж, цэвэр цэмцгэр байдлыг хангах, өвчтөн үйлчлүүлэгчиддээ тав тухтай орчинг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байдаг үйлчилгээний ажилтнуудынхаа ажлын байрны нөхцлийг сайжруулах зорилгоор цэвэрлэгээний тэргэнцэрээр хангасан. Эрүүл мэндийн байгууллагын үйлчлэгч нарын хувьд халдвар хамгаалал, эрүүл ахуйн хатуу стандарт бүхий дүрэм, журмын дагуу цэвэрлэгээ үйлчилгээг хийдэг учир цэвэрлэгээний тэргэнцэртэй болсноор цэвэрлэгээний багаж хэрэгсэл,





ариутгалын бодис, арчих материалыг стандартын дагуу нэг дор авч явах боломж бүрдсэн.

Энэ нь НЭМГ-аас зохион байгуулсан “Сайн туршлага-2019” арга хэмжээнд “Цэвэрлэгээ үйлчилгээний тэргэнцэр” бүтээлээр оролцож “Шилдэг бүтээл”ээр шалгарч сайн туршлагын

санд бүртгэгдсэн.

Төвийн цахилгаан тасадсан үед ажиллуулах цахилгаан үүсгүүрийг байрлуулан холбож, гадна байрыг барьж, ашиглалтанд орууллаа.



Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдал, тав тух, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, усны алдагдлыг бууруулах зорилгоор 5,4 сая төгрөгөөр 30 суултуур, гар тохойн ажиллагаатай 30 крантыг иж бүрнээр сольсон.

НЭМТ-өөр үйлчлүүлж байгаа ХБИ-д зориулсан ариун цэвэрийн өрөөг Дүүргийн засаг даргын 1,8 сая төгрөгийн санхүүжилтээр засварлалаа.



ОЛОЛТ, АМЖИЛТУУДААС:

Нийслэлийн Эрүүл мэндийн газраас Эрүүл мэндийн чанарын холбоотой хамтран 2019.10.11-ний өдөр Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт зохион байгуулсан “Сайн туршлага-2019” арга хэмжээнд манай хамт олон нийт 49 бүтээлээр амжилттай оролцож шагнагдсан. Үүнд:

1. “Сайн туршлага-2018” арга хэмжээний үеэр олонд танилцуулсан шинэ бүтээл, дэвшилтэт технологи, тусламж, үйлчилгээний аргачлалаас өөрсдийн оношилгоо, эмчилгээ, сувилгаа, үйлчилгээндээ нэвтрүүлэн нутагшуулж, түгээн дэлгэрүүлсэн 13 бүтээлээр **“ӨРГӨМЖЛӨЛ, МӨНГӨН ШАГНАЛ”**
2. Гэмтлийн 14 төрлийн мэс заслын эмчилгээ /Мэс засал, эмэгтэйчүүдийн тасаг/ - **Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний технологиор Тэргүүн байр**
3. Ахуй заслын өрөө /Уламжлалт сэргээн засах эмчилгээний тасаг/ - **Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмж сайжруулах, аюулгүй байдлыг шийдвэрлэн ажилласан бүтээлээр Дэд байр**
4. Цэвэрлэгээ үйлчилгээний тэргэнцэр /Аж ахуй үйлчилгээний тасаг/ - **Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний технологиор шалгарч “ГЭРЧИЛГЭЭ” авсан.**



Тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэнтэй холбоотой тайлант хугацаанд:

- “Сүрьеэгүй дүүрэг” дэд хөтөлбөрийг дүүргийн ЗД-ын дэмжлэгтэйгээр орон нутагтаа амжилттай хэрэгжүүлж эхэлсэн.
- Гэмтлийн хагалгааг орон нутагтаа хийж байгаа бөгөөд хагалгааны дараа хүндрэл гараагүй.
- Хүүхдийн мэдээгүйжүүлэг, хүүхдийн мэс заслыг орон нутагтаа хийж эхэлсэн.
- Хавдрын үеийн өдрийн болон 48 цагийн хими эмчилгээг орон нутагт хийж тогтмолжсон төдийгүй 2017 оны 05 сараас хойш 2 жилийн хугацаанд хими эмчилгээнд орсон бүх эмчлүүлэгч нар дахилт, сэдрэл өгөөгүй, хүндрэл гараагүй байгаа нь эмчилгээний үр дүн сайн болохыг харуулж байна.
- Ходоодны дурангийн оношлогооны үйл ажиллагаа жигдэрсэн.
- Тархины цахилгаан бичлэг хийж эхэлсэн.
- Дижитал рентген аппараттай болж оношлогооны чадавхи сайжирсан.
- Шүдний цооролтын эмчилгээнд сүүлийн үеийн үр дүн сайтай материалуудыг хэрэглэснээр давтан эмчилгээний давтамж багасч, үйлчлүүлэгч олон ирэхийг цөөрүүлсэн.

Бусад:

Нийслэлийн Эрүүл мэндийн газраас харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр “Шинэ арга, технологи нэвтрүүлсэн байгууллага”-аар шалгарсан.



"Даралт ихсэлтийн урьдчилан сэргийлэлт, эрт оношлох, хяналтыг сайжруулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, "Оном" сангаас хамтран хэрэгжүүлж буй "ЭРҮҮЛ ЗҮРХ-ЭРҮҮЛ УЛААНБААТАР" хөтөлбөрийн хүрээнд даралт ихсэлтийн эрт илрүүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, тусламж, үйлчилгээний менежментийг оновчтой зохион байгуулах, оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж ажилласан шилдэг ӨЭМТ болон өрхийн эмчээр Энх-Өрх ӨЭМТ болон ахлах эмч Х.Өнөржаргал шалгарч шагнагдсан.



Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан Багануур, Налайх, Багахангай дүүргийн ЭМТ-ийн сувилагч, тусгай мэргэжилтэнүүдийн дунд 3-н төрөлт спортын тэмцээн зохион байгуулагдсан ЭМТ-өөс 28 сувилагч тусгай мэргэжилтэн багийн зохион байгуулалтай оролцон 18 алт, мөнгө, хүрэл медалийг авч амжилттай оролцсон.



2020 ОНД БИД:

- Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтэндээ дүгнэлт хийн улам сайжруулах бодлого, зорилтыг дэвшүүлэн ажиллах
- Эмч мэргэжилтнүүдийн ёс зүй, хандлагыг дээшлүүлэх чиглэлд үр дүнтэй ажил зохиох
- Ажилтнуудын нийгмийн асуудалд онцгойлон анхаарах
- ЭМТ-ийн өргөтгөл /төрөх тасаг/-ийн барилгыг дуусгаж, ашиглалтанд оруулах /2019 онд 1,4 тэрбум, 2020 онд 1 тэрбум/
- ЭМТ-ийн өргөтгөл /төрөх тасаг/ 2020 онд ашиглалтанд ороход шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга эд хогшилын зардал 800 сая.төг, болон хүний нөөц, тогтмол зардлын санхүүжилтийг олох
- ЭМТ-ийн барилгын гадна фасадны их засвар хийх
- Компьютер томографаар хангагдах
- Яаралтай түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийх
- Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээг өргөжүүлэх
- Ажилчдын орон сууцны барилгыг эхлүүлэх
- Сантехникийн ил шугам сүлжээний засвар: *Төвийн барилга ашиглалтанд орсноос хойш 30 жил сантехник шугам сүлжээнд загвар огт хийгдээгүй. Шугам нь хэт элэгдэлд орсноос гагнуур хийх боломжгүй болж цоорхойнуудыг хаймар тавин боож аргацааж байна. 2017 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 70,254,093 төгрөгний далд шугамны засвар үйлчилгээ хийсэн.*
- Нийгмийн эрүүл мэндийн төвийн орон тоог нэмэгдүүлэх, бие даалгах:
- Сүүлийн жилүүдэд үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Нийгмийн эрүүл мэндийн төв, молекул биологийн лаборатори, нярайн эмгэгийн тасаг, гемодиализийн тасгийг шинээр нээж, цусны салбар банк, төвлөрсөн ариутгалын хэсэг, хими эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээ, уламжлалт сэргээн засах болон мэс заслын тусламж үйлчилгээг өргөтгөж байгаа учир бүтэц орон тоогоо шинэчлэн батлуулах
- Эмч, эмнэлгийн ажилчдыг гадаад болон дотоодын мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтанд хамруулах
- Түргэн тусламжийн автомашин, парк шинэчлэл хийх

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН,
ЭДИЙН ЗАСАГЧ

Д.МӨНГӨНЦАЦРАЛ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА

Д.ШИНЭБАЯР